



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 1 (478)

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Төлбөр хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай*
- *Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2007 он



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2007 оны нэгдүгээр сарын 7

№1 (478)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1.	Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай	Дугаар 263	1
2.	Журам батлах тухай	Дугаар 272	9
3.	Төлбөр хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 280	12
4.	Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр батлах тухай	Дугаар 282	12

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

5.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2, 111.5 заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 12	22
6.	Засгийн газрын "Журам батлах тухай" 2005 оны 208 дугаар тогтоолын зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 13	25

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 11 дүгээр сарын 9-ний өдөр

Дугаар 263

Улаанбаатар хот

#### Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай

Шүүхийн тухай хууль, Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх Үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр, "Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. "Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2005

оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 66 дугаар тогтоолын 17 дугаар хавсралтад "44. Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Үндэсний зөвлөл - Хууль зүй, дотоод хэргийн сайд" гэж нэмсүгэй.

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн төсөв болон гадаад орон, олон улсын байгууллагын хандив, тусламжийн хүрээнд зохицуулан шийдвэрлэж байхыг Сангийн сайд Н.Баяртсайханд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД

Д.ОДБАЯР

Засгийн газрын 2006 оны 263 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

## ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭНД ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

### Нэг. Өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт Монгол Улсын иргэн нь Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй болохыг баталгаажуулсан бөгөөд Үндсэн хуулийн Тавин тавдугаар зүйлд шүүгдэгчийн өөрийгөө өмгөөлөх эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэхээр заасан.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 39 дүгээр зүйлд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өөрөө өмгөөлөгч сонгох талаар заасан бөгөөд өмгөөлөгчөө сонгож аваагүй бол хүсэлтээр нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх энэ эрхийг хангах үүрэгтэй. Шүүхийн тухай хуульд зааснаар шүүгдэгч болон шүүхээр эрхээ хамгаалуулж байгаа аливаа этгээд өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгчөө чөлөөтэй сонгон авах тухай заасан боловч ядуу, орлого багатай, төлбөрийн чадваргүй иргэд энэ эрхээ тэр бүр эдэлж чадахгүй байна.

Монгол Улсад эрүүгийн хэрэгт холбогдсон, ял эдэлж байгаа хүмүүсийн 80 орчим хувь нь нэн ядуу, ядуу, боловсролын түвшин доогуур, эсхүл боловсролгүй, ажилгүй байна. Өөрөөр хэлбэл төлбөрийн чадваргүй буюу амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур амьдралтай иргэд гэмт хэрэг үйлдэх нь ихэсч байна. Тухайлбал, 2005 онд улсын хэмжээнд 10153 этгээд ял шийтгүүлснээс 7206 буюу 70.9 хувь нь төлбөрийн чадваргүй байх магадлалтай хүмүүст хамаарч байна.

Шүүхийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, Өмгөөллийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд "Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Уг зардлыг санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина" гэж заасан бөгөөд үүний дагуу улсын төсвөөс 2002 онд 9 сая, 2003 онд 9 сая, 2004, 2005, 2006 онд тус тус 12 сая төгрөгийг Монголын өмгөөлөгчдийн холбоонд шилжүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 69 дүгээр тушаалаар баталсан "Төлбөрийн

чадваргүй иргэний өмгөөллийн хөлсний жишгийг тогтоох, зардлыг төсвөөс санхүүжүүлэх, тайлан гаргах журам"-аар өмгөөллийн хөлсний жишгийг хөнгөн хэрэгт 12600, хүндэвтэр хэрэгт 21600, хүнд хэрэгт 28800, онц хүнд хэрэгт 43200 төгрөгөөр тус тус тогтоосон.

Өмгөөллийн тухай хуулиар өмгөөлөгч жилд 2 удаа төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөх үүрэг хүлээсэн байдаг. Гэвч төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн хөлс, ялангуяа хөнгөн, хүндэвтэр хэрэгт олгох хөлсний хэмжээ харьцангуй бага байдгаас хэрэг, маргаанд өмгөөлөгчөөр оролцох сонирхол байдаггүй бөгөөд тэдгээр нь үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэхээс байнга татгалздаг болно.

2006 оны 8 дугаар сарын байдлаар Монгол Улсад 1300 гаруй өмгөөлөгч байгаагаас 1100 орчим нь Улаанбаатар хотод төвлөрдөг тул хөдөө орон нутагт мэргэжлийн өмгөөлөгчийн хүрэлцээгүйгээс төлбөрийн чадваргүй иргэд хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй авах эрхээ хэрэгжүүлэх боломжгүй байгаа юм.

Хууль тогтоомжийн хэрэгжилт, зохион байгуулалт хангалтгүй, шаардлагатай эрх зүйн тогтолцоо бүрдээгүй, өмгөөлөгчийн ажлын чанарт хяналт тавих хариуцлагын тогтолцоо байхгүй, түүнчлэн хууль зүйн туслалцаанд зориулж төсвөөс олгодог санхүүжилт маш бага байгаагаас нийгмийн эмзэг бүлэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх хуулийн заалт төдийлэн сайн хэрэгжихгүй байна.

1999 оноос эхлэн МУИС-ийн Хууль зүйн сургууль, Шихихутуг, БИС дээр Хууль зүйн клиник төвүүд ажиллаж байгаа бөгөөд төвүүдэд хуулийн сургуулийн төгссөн ангийн оюутнууд багшийн удирдлага дор ажиллаж нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлж байна.

Түүнчлэн Хүний эрх хөгжил төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хуульч эмэгтэйчүүдийн холбоо зэрэг төрийн бус байгууллагууд иргэдэд үнэ төлбөргүй эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлж байна.

Цаашид өмгөөллийн хөлс төлөх чадваргүй иргэдийн эрх ашгийг хамгаалан ажиллахад төрийн бус байгууллага, хууль зүйн клиник төвүүдийн оролцоог эрчимжүүлэх, төлбөрийн чадваргүй иргэдэд эрх ашгаа хамгаалах талаар сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна.

Төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн туслалцааг үнэ төлбөргүй хүргэх боломжийн талаар иргэдийн санал бодлыг тодруулахаар судалгаа явуулсан бөгөөд судалгаанд хамрагдагсдын 64,6 хувь нь энэ чиглэлээр тусгайлан байгууллага байгуулах хэрэгтэй, 27,1 хувь нь тодорхой төрийн байгууллага, албан тушаалтанд хариуцуулах нь зүйтэй, 8,3 хувь нь мэдэхгүй байна гэжээ. Энэ нь төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцааг "тусгайлан байгууллага" байгуулах арга хэлбэрээр үнэ төлбөргүй хүргэхийг иргэд дэмжиж байгааг илэрхийлж байна.

Түүнчлэн олон нийтэд эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөөг хамгийн үр нөлөөтэй өгч чадах байгууллагаар дээрх судалгаанд оролцогчдын 80 орчим хувь нь "Өмгөөллийн туслалцаа үзүүлэх төв" /Эрх зүйн туслалцааны төв/-ийг нэрлэжээ.

Дээр дурдсан байдлаас үзэхэд төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх бие даасан тогтолцоотой болох, түүнийг тодорхой бодлого, чиглэлтэйгээр шийдвэрлэж, хэрэгжүүлэх, Эрх зүйн туслалцааны төвийг бүх аймаг, дүүрэгт байгуулах асуудал чухлаар тавигдаж байна.

## Хоёр. Хөтөлбөрийн зорилго

2.1. Төлбөрийн чадваргүй иргэдэд эрүүгийн хэргийн бүх шатанд хууль зүйн туслалцаа үзүүлэх үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж, хууль зүйн туслалцааны хүртээмж, чанар болон иргэдийн эрх зүйн боловсролыг сайжруулах талаар дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Энэхүү хөтөлбөрийн эрхэм зорилго нь иргэдийн санхүүгийн байдлаас үл хамааран хууль зүйн туслалцааг тэгш, хүртээмжтэй, үр дүнтэй үзүүлэх үндэсний тогтолцоог бий болгох явдал юм.

## Гурав. Хөтөлбөрийн зорилтууд

3.1. Дээрх зорилгын хүрээнд дараахь зорилтуудыг хэрэгжүүлнэ:

3.1.1. Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг хариуцсан буюу төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, эрх зүйн албан бус сургалт, сурталчилгаа зохион байгуулах ажлыг хэрэгжүүлэх, уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөлийг байгуулах;

3.1.2. Үндэсний хөтөлбөрийн хүрээнд хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх үйл ажиллагаа, эрх зүйн сурталчилгаа, албан бус сургалтын чанар, хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэх ажлыг Монгол Улсад хамгийн тохиромжтой хэлбэрээр зохион байгуулах.

Туршилтын журмаар ажиллаж байгаа төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн туслалцаа үзүүлэх улсын өмгөөлөгчийн загвар-Эрх зүйн туслалцааны төвийг улсын хэмжээнд дэлгэрүүлэх;

3.1.3. Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдон үүсэх хариуцааны эрх зүйн зохицуулалтыг бий болгох талаар зөвлөмж гаргах;

3.1.4. Төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлж байгаа хууль зүйн туслалцааны чанарын болон хяналтын стандарт боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулах, иргэнийг төлбөрийн чадваргүйд тооцох өнөөгийн шалгуурыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох;

3.1.5. Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх санхүүгийн эх үүсвэрийг бий болгох асуудлыг судлан шийдвэрлүүлэх;

3.1.6. Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр Монголын өмгөөлөгчдийн холбоо, холбогдох төрийн бус байгууллага, хууль зүйн клиникүүдийн үйл ажиллагааг дэмжин, Төвийн үйл ажиллагаатай уялдуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3.1.7. Орон нутагт эрх зүйн мэдээлэл, лавлагаа, хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэх.

## Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагаатай нягт уялдуулах, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн сургууль, Монголын өмгөөлөгчдийн холбоог идэвхтэй оролцуулах, тэдгээрийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, санхүүгийн эх үүсвэрийг хүртээмжтэй, үр ашигтайгаар хуваарилах зарчмыг баримтлана.

## Тав. Хөтөлбөрийн үйл ажиллагааны чиглэл

5.1. Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг хариуцсан буюу эрх зүйн албан бус сургалт, сурталчилгааны бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, уялдуулан зохицуулах чиг үүрэг бүхий байгууллага байгуулах чиглэлээр:

5.1.1. Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг хариуцсан Хууль зүй, дотоод хэргийн яам, Монголын өмгөөлөгчдийн холбоо, Хүний эрхийн

үндэсний комисс болон хууль зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, холбогдох бусад байгууллагын төлөөлөл бүхий Үндэсний зөвлөлийг байгуулна. Үндэсний зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд түүнийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн удирдаж бүрэлдэхүүнийг батална.

Үндэсний зөвлөл нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

-хууль зүйн туслалцаа үзүүлэх, эрх зүйн сурталчилгаа, албан бус сургалтын талаар бодлого боловсруулахад туслэх, зөвлөмж гаргах, бодлогыг хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохицуулах, холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг хангах, хууль зүйн туслалцааны санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, түүний зарцуулалтад хяналт тавих;

-эрх зүйн туслалцааны төвүүдийг байгуулах, тэдгээрийн үйл ажиллагааны хэтийн төлөвийг тодорхойлоход дэмжлэг үзүүлж удирдлагаар хангах;

-орон нутагт хууль зүйн анхан шатны туслалцаа үзүүлэх, мэдээлэл, сурталчилгаа явуулах үйл ажиллагааны үндсэн чиглэл, хэтийн төлөвийг тодорхойлох;

-орон нутгийн түвшинд улсын өмгөөллийн үйл ажиллагааг явуулах болон хууль зүйн анхан шатны туслалцаа үзүүлэх, мэдээлэл, сурталчилгаа явуулах нөхцөлөөр хангах;

-эрх зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх үйл ажиллагааг явуулахад шаардлагатай эрх зүйн акт, зөвлөмжийг боловсруулан шийдвэрлүүлэх;

-эрх зүйн үнэ төлбөргүй туслалцааны чанарын болон хяналт шалгалтын стандартуудыг эрх зүйн туслалцааны төвүүдтэй хамтран боловсруулж батлуулах;

-төлбөрийн чадваргүй байдлыг тогтоох шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах;

-төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх эрх зүйн туслалцааны хүртээмжтэй байдлыг хангах талаар байгууллагын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, ажлыг нь сайжруулах чиглэлээр зөвлөмж гаргах;

-эрх зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх эжилд шаардагдах төсвийг батлуулах;

-өтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллагын хандяв, тусламж ашиглах боломжийг судалж шийдвэрлүүлэх;

-хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх хувийн өмгөөлөгчийн хөлсний

хэмжээг тогтоох шалгуур үзүүлэлтийг боловсруулах;

-Эрх зүйн туслалцааны төв байгуулагдаагүй нутаг дэвсгэрт эрх зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх ажлыг зохион байгуулах;

-хүний нөөц болоод санхүүгийн эх үүсвэрийг үр дүнтэй ашиглах менежментийн бодлого явуулах.

5.2. Хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх үйл ажиллагаа, эрх зүйн сурталчилгаа, албан бус сургалтын чанар, хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэх ажлыг Монгол Улсад хамгийн тохиромжтой хэлбэрээр зохион байгуулах. Төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн туслалцаа үзүүлэх туршилтын журмаар ажиллаж байгаа улсын өмгөөлөгчийн загвар-Эрх зүйн туслалцааны төвийг улсын хэмжээнд дэлгэрүүлэх чиглэлээр:

5.2.1. Эрүүгийн хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх, орон нутагт эрүү, иргэн, захиргааны хэрэгт анхан шатны хууль зүйн зөвлөгөө өгөх, эрх зүйн албан бус сургалт, сурталчилгаа явуулах зорилгоор Эрх зүйн туслалцааны төвийг байгуулан ажиллуулна;

5.2.2. Төвүүдийг улсын хэмжээнд байгуулах бүх бололцоог судлан, гадаад дотоодын байгууллагын дэмжлэг, туслалцаа авах ажлыг зохион байгуулна;

5.2.3. Төвд орон тооны улсын өмгөөлөгчдийг ажиллуулна. Төвд ажиллах төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчдийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр шалгаруулж гэрээ байгуулан ажиллуулна;

5.2.4. Орон нутагт эрүү, иргэн, захиргааны хэрэгт анхан шатны хууль зүйн зөвлөгөө өгөх, эрх зүйн албан бус сургалт, сурталчилгаа явуулах ажлыг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран гүйцэтгэнэ;

5.2.5. Төвд 1-3 өмгөөлөгч, аймаг, дүүргийн хуулийн хэлтсийн 1 мэргэжилтэн ажиллана. Тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн ам болон гарч байгаа хэргийн тоо, төлбөрийн чадваргүй иргэдийн эзлэх хувь зэргийг үндэслэн төвд ажиллах орон тооны өмгөөлөгчийн тоог тогтооно;

5.2.6. Эрх зүйн туслалцааны төвийн чиг үүрэг:

-төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн чанартай туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх;

-эрүү, иргэн, захиргааны хэрэгт анхан шатны хууль зүйн зөвлөгөө өгөх;

-эрх зүйн албан бус сургалт, сурталчилгаа явуулах;

-хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлсэн талаархи статистик мэдээг Үндэсний зөвлөлд гаргаж, ажлаа тайлагнаж байх;

-иргэний төлбөрийн чадваргүйг тогтоох сорил авах;

-хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх өмгөөлөгчийг хуваарилах;

-ажлын ачаалал нэмэгдэх болон шаардлагатай бусад тохиолдолд хувийн өмгөөлөгчтэй гэрээ байгуулан ажиллах;

-өмгөөлөгчийн үйл ажиллагаанд чанарын хяналт тавих.

**5.3. Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдон үүсэх харилцааны эрх зүйн зохицуулалтыг бий болгох чиглэлээр:**

**5.3.1. Үндэсний зөвлөл нь** хөтөлбөрт тусгагдсан бодлогын шинжтэй арга хэмжээг зохион байгуулах, улсын өмгөөлөгчийн эрх зүйн байдал, туслалцаа үзүүлэх хэлбэр, журам, үнэ төлбөргүй туслалцааны хамрах хүрээ зэргийг тодорхойлсон холбогдох хууль, эрх зүйн актын төсөл боловсруулж, батлуулах арга хэмжээ авч, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулна;

**5.3.2. Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог бий болгож өмгөөллийн үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтын чиг үүргээс нарийн зааглаж өгнө.**

**5.4. Төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлж байгаа хууль зүйн туслалцааны чанарын болон хяналтын стандартыг боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулах, төлбөрийн чадваргүй байдлыг тогтоох аргачлалыг боловсронгуй болгох чиглэлээр:**

**5.4.1. Эрх зүйн туслалцааны төвтэй хамтран үнэ төлбөргүй үзүүлэх эрх зүйн туслалцааны чанарын болон хяналтын стандартыг боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулж, мөрдүүлэх;**

**5.4.2. Төлбөрийн чадваргүй нийт иргэдийн судалгааг гаргах, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн төлбөрийн чадваргүйг нотолсон тодорхойлолтыг оршин суугаа баг, хороо, сум,**

**дүүргээс олгох нь хүндрэлтэй байгаа тул гадаадын туршлагаас судалж, төлбөрийн чадваргүй байдлыг тогтоох шалгуур үзүүлэлтийг боловсруулах, хууль тогтоомжид тусгах арга хэмжээ авах.**

**5.5. Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх санхүүгийн эх үүсвэрийг бий болгох асуудлыг судлан шийдвэрлүүлэх чиглэлээр:**

**5.5.1. Хөтөлбөрийг төсөв, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ;**

**5.5.2. Үндэсний зөвлөл эрх зүйн туслалцааны төвийн өмгөөллийн болон хууль зүйн зөвлөгөө өгөх, эрх зүйн сурталчилгаа, албан бус сургалт явуулах үйл ажиллагааг иргэдэд чанартай, үр дүнтэй хүргэхийн тулд төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэхэд төсвөөс шаардлагад нийт зардлын тооцоог гаргаж, уг тооцоог үндэслэн төсөв, олон улсын байгууллагууд, төрийн бус байгууллагаас санхүүжилт авах боломж, бололцоог судлан, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авна;**

**5.5.3. Өмгөөллийн хөлс төлөх журмыг өөрчлөн, асуудлыг хүндрэлгүй зохион байгуулах, ялангуяа төсвөөс олгох хөлсийг баталгаатай болгож, төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлсний дараа өмгөөлөгчийн хөлсийг нэн даруй олгодог тогтолцоог бүрдүүлнэ.**

**5.6. Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр Монголын өмгөөлөгчдийн холбоо, төрийн бус байгууллага, хууль зүйн клиникүүдийн үйл ажиллагааг дэмжих, тэдгээрийн ажлын уялдааг хангах чиглэлээр:**

**5.6.1. Хуулийн сургуулийн клиник сургалтын төвийн нөөц бололцоог ашиглах, төгсөх ангийн оюутнууд болон шинэ төгсөгчдийг төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажилд өргөнөөр оролцуулах ажлыг дэс дараатай зохион байгуулна;**

**5.6.2. Бүх хуулийн сургуулийг хууль зүйн клиниктэй болгох бололцоог судална;**

**5.6.3. Иргэдийн эрх зүйн боловсрол, түүний дотор өмгөөлүүлэх эрхээ эдлэх талаархи мэдлэгийг дээшлүүлэхэд өмгөөллийн болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэх арга хэмжээ авна;**

**5.6.4. Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөлөхтэй холбоотой онцлог, үүрэг, ач холбогдлын талаар төрөлжсөн сургалтыг зохион явуулна;**

5.6.5. Өмгөөлөгчдөөс төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх сайн дурын өмгөөллийг Монголын өмгөөлөгчдийн холбоотой хамтран өргөжүүлнэ;

5.6.6. Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлдэг өмгөөлөгч, төрийн бус байгууллагын ажилтнууд, хуулийн ангийн оюутнуудад зориулсан сургалт зохион байгуулж, гарын авлага боловсруулна.

5.7. Орон нутагт эрх зүйн мэдээлэл, лавлагаа, хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр:

5.7.1. Орон нутагт эрх зүйн мэдээлэл, лавлагаа, хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор эрх зүйн төвийн хүрээнд эрх зүйн хөтөч /эрх зүйн сургалт, сурталчилгааны ажилтан/-ийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

5.7.2. Иргэдэд эрх зүйн зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгааны ажлыг орон нутагт зохион байгуулах чиглэлээр аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газраас Эрх зүйн туслалцааны төвтэй хамтран ажиллана;

5.7.3. Орон нутагт иргэдэд эрх зүйн зөвлөгөө өгөх, эрх зүйн сурталчилгаа, албан бус сургалт явуулах ажилтнуудыг бэлтгэх, сургах, тэдгээрийн ажлын удирдамжийг боловсруулна.

## **Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа**

6.1. Хөтөлбөрийг 2012 он хүртэл хугацаанд 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

I үе шат – (2006-2011 он)-ыг хэрэгжүүлэхэд дор дурдсан үйл ажиллагааг явуулна:

-Үндэсний зөвлөлийг байгуулан ажиллуулах;

-холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын төсөл боловсруулж батлуулах;

-Эрх зүйн туслалцааны төвийг бүх аймаг, дүүрэгт байгуулах;

-төвд ажиллах улсын өмгөөлөгчийг сонгон шалгаруулж тэдгээртэй гэрээ байгуулах;

-иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх, эрх зүйн сурталчилгаа, албан бус сургалт явуулах ажлыг зохион байгуулах;

-орон нутагт иргэдэд эрүү, иргэн, захиргааны чиглэлээр хууль зүйн анхан шатны

зөвлөгөө өгөх, эрх зүйн сурталчилгаа, албан бус сургалт явуулах ажилтныг сургах, тэдгээрийн ажлын удирдамжийг боловсруулах;

-эрх зүйн туслалцааны чанарын болон хяналтын стандартуудыг Эрх зүйн туслалцааны төвтэй хамтран боловсруулж батлуулан мөрдүүлэх;

-төлбөрийн чадваргүй байдлыг тогтоох шалгуур үзүүлэлтийг боловсруулж мөрдүүлэх;

-төлбөрийн чадваргүй иргэдийн хууль зүйн туслалцааны зардлыг улсын төсөв, төсөл, хандивын хөрөнгөөр санхүүжүүлэх бололцоог судлан шийдвэрлүүлэх;

-хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлэх хувийн өмгөөлөгчийн хөлсний хэмжээг тогтоох шалгуур үзүүлэлтийг тодорхойлох;

-орон нутагт иргэдэд эрх зүйн зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

-орон нутагт эрх зүйн мэдээлэл, лавлагаа, хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор эрх зүйн төвийн хүрээнд эрх зүйн хөтөч /эрх зүйн сургалт, сурталчилгааны ажилтан/-ийн үйлчилгээг нэвтрүүлэх;

-орон нутагт иргэдэд эрх зүйн зөвлөгөө өгөх, эрх зүйн сурталчилгаа, албан бус сургалт явуулах ажилтныг бэлтгэх, сургах, тэдгээрийн ажлын удирдамж, стандартыг боловсруулан мөрдүүлэх;

-иргэдийн эрх зүйн боловсрол, түүний дотор өмгөөлүүлэх эрхээ эдлэх талаар ямар үр дүнд хүрснийг тодорхойлох, судалгаа явуулах.

II үе шат – (2012 он)-ыг хэрэгжүүлэхэд дор дурдсан үйл ажиллагаа явуулна:

-Эрх зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг чанартай, хүртээмжтэй, үр дүнтэй, тогтвортой явуулах бүх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ;

-Эрх зүйн туслалцааны төвийн санхүүжилтийн асуудлыг эцэслэн шийдвэрлүүлнэ.

## **Долоо. Хүрэх үр дүн**

Энэхүү хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлснээр Монгол Улсад төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх хууль, эрх зүйн таатай орчин бүрдэж, хэрэгжилтэд нь хяналт тавих боломжтой болно.



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2007 он №1 (478)

## ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭЭНД ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЦАА ҮЗҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилт	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцан гүйцэтгэх байгууллага
1.	Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх, тогтолцоог боловсронгуй болгох, туршилтын журмаар ажиллаж байгаа Эрх зүйн туслалцааны төвийг дэлгэрүүлэх	Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг хариуцсан Үндэсний зөвлөлийг байгуулах Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх Эрх зүйн туслалцааны төвийг байгуулах, орон тооны улсын өмгөөлөгчидтэй гэрээ байгуулан ажиллуулах Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчдийн ажлын байр бий болгох, ажиллах нөхцөлөөр хангах, ажлыг нь дүгнэх хариуцлагын тогтолцоотой болгох арга хэмжээ авч шийдвэрлүүлэх Эрх зүйн туслалцааны төвүүдийн үйл ажиллагааг тогтворжуулах	2006 он  2006-2012 он  2006-2012 он	ХЗДХЯ  Үндэсний Зөвлөл, ХЗДХЯ  Үндэсний Зөвлөл, ХЗДХЯ, СЯ, МӨХ
2.	Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдон Үүсэх харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн актын төсөл боловсруулж батлуулах	Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог бий болгох чиглэлээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хөтөлбөрт тусгагдсан бодлогын шинжтэй арга хэмжээг зохион байгуулах, улсын өмгөөлөгчийн эрх зүйн байдал, туслалцаа үзүүлэх хэлбэр, журам, үнэ төлбөргүй туслалцааны хамрах хүрээ зэргийг тодорхойлсон хууль, эрх зүйн актын төсөл боловсруулж, батлуулах арга хэмжээ авч, тэдгэрийн хэрэгжилтийг зохион байгуулах Эрх зүйн үнэ төлбөргүй туслалцааны чанарын болон хяналтын стандартыг Эрх зүйн туслалцааны төвүүдтэй хамтран боловсруулж батлуулан мөрдүүлэх	2012 он	Үндэсний Зөвлөл, ХЗДХЯ, СЯ, МӨХ
3.	Төлбөрийн чадваргүйд тооцох аргачлалыг боловсронгуй болгох, Эрх зүйн туслалцааны чанарын болон хяналтын стандартыг боловсруулан мөрдүүлэх	Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх санхүүгийн эх үүсвэрийг бий болгох асуудлыг судлан шийдвэрлүүлэх	2006-2008 он	Үндэсний Зөвлөл, ХЗДХЯ
4.	Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх санхүүгийн эх үүсвэрийг бий болгох асуудлыг судлан шийдвэрлүүлэх	Төлбөрийн чадваргүй нийт иргэдийн судалгааг гаргаж, гадаадын туршлагаас судлах, Төлбөрийн чадваргүй байдлыг тогтоох шалгуур үзүүлэлтийг боловсруулах, хууль тогтоомжид тусгах арга хэмжээ авч Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардагдах зардлын урьдчилсан тооцоо гаргаж түүнийг үндэслэн төсөв, олон улсын байгууллага, төрийн бус байгууллагаас санхүүжилт авах боломж бололцоог судлан шийдвэрлүүлэх	2006-2008 он	Үндэсний Зөвлөл, ХЗДХЯ
			2006-2008 он	Үндэсний Зөвлөл, ХЗДХЯ, СЯ



	<p>Сайн дурын үндсэн дээр анхан шатны хууль зүйн туслалцаа үзүүлэх боломжтой төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах</p> <p>Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай бүрт өмгөөлөгчийн хөлсийг нэн даруй олгодог тогтолцоог бүрдүүлэх ажлыг зохион байгуулах</p>	<p>2006-2011 он</p>	<p>Үндэсний Зөвлөл, ХЗДХЯ, МӨХ</p>
	<p>Хуулийн сургуулийн клиник сургалтын төвийн нөөц бололцоог ашиглах, хуулийн сургуулийн төгсөх ангийн оюутнууд болон шинэ төгсөгчдийг төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх ажилд өргөнөөр оролцуулах ажлыг дэс дараатайгаар зохион байгуулах</p> <p>Бүх хуулийн сургуулиудыг хууль зүйн клиниктэй болгох боломжийг судлах</p>	<p>2006-2008 он</p>	<p>ХЗДХЯ, Хууль зүйн клиник төвүүд</p>
<p>5.</p>	<p>Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр МӨХ төрийн бус байгууллага, хууль зүйн клиникуудын үйл ажиллагааг дэмжин, тэдний ажлын үндэсний хангах</p>	<p>2006-2008 он</p>	<p>Үндэсний Зөвлөл, ХЗДХЯ, Хуулийн сургуулиуд</p>
	<p>Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлдэг өмгөөлөгч, төрийн бус байгууллагын ажилтнууд, хуулийн ангийн оюутнуудад зориулсан гарын авлага боловсруулах</p> <p>Төлбөрийн чадваргүй иргэдийг өмгөөлөхтэй холбоотой онцлог, үүрэг, ач холбогдлын тухай төрөлжсөн сургалтыг зохион явуулах</p>	<p>2006-2008 он</p>	<p>Үндэсний Зөвлөл, ХЗДХЯ, МӨХ</p>
<p>6</p>	<p>Орон нутагт эрх зүйн мэдрэл, лавлагаа, хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах, үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэх</p>	<p>2006-2009 он</p>	<p>Үндэсний Зөвлөл, ХЗДХЯ, МӨХ</p>
	<p>Орон нутагт эрх зүйн мэдээлэл, лавлагаа, хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор эрх зүйн хөлч (эрх зүйн сургалт, сурталчилгааны ажилтан)-ийн үйлчилгээг нэвтрүүлэх</p> <p>Аймаг дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтарч орон нутагт иргэдэд эрх зүйн зөвлөгөө өгөх, сурталчилгаа, албан бус сургалт явуулах ажлыг зохион байгуулах</p> <p>Орон нутагт иргэдэд эрх зүйн зөвлөгөө өгөх, эрх зүйн сурталчилгаа, албан бус сургалт явуулах ажлын удирдамжийг боловсруулж мөрдүүлэх</p>	<p>2006-2012 он</p>	<p>ХЗДХЯ, МӨХ, Засаг дарга нар</p>
		<p>2006-2012 он</p>	<p>Үндэсний Зөвлөл, ХЗДХЯ, МӨХ, Засаг дарга нар</p>

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Дугаар 272

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 58.4, 59.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Н.Баяртсайханд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

САНГИЙН САЙД  
Засгийн газрын 2006 оны 272 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

Н.БАЯРТСАЙХАН

### АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙГ ТӨЛӨХ, ХУВААРИЛАХ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төсөвт төлөх, хуваарилах, зарцуулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

2. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу олборлож худалдсан, худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс тооцно.

#### Хоёр. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төсөвт төлөх

3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын нутаг дэвсгэрээс олборлож худалдсан, худалдахаар ачуулсан болон ашигласан алт, зэс, зэсийн баяжмалын борлуулалтын үнэлгээнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг улсын төсвийн дансанд төлнө.

4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын нутаг дэвсгэрээс олборлож худалдсан, худалдахаар ачуулсан болон ашигласан алт, зэс, зэсийн баяжмалаас бусад ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг тухайн ашигт малтмалын орд байршиж байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн дансанд төлнө.

5. Тусгай зөвшөөрөл бүхий алт олборлогч олборлосон алтыг Монгол банк болон арилжааны банкинд тушаах тухай бүр олборлосон алтанд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлнө.

6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон алтыг экспортод гарган худалдсан, худалдахаар ачуулсан бол борлуулалтын үнэлгээнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг борлуулалт, эсхүл ачилт

хийснээс хойш 7 хоногийн дотор улсын төсвийн дансанд төлнө.

7. Монгол банк болон арилжааны банк иргэд, хуулийн этгээдийн тушаасан алтны борлуулалтын үнэлгээнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг алт тушаасан тухай бүр хуульд заасан хувь хэмжээгээр суутгаж, улсын төсвийн дансанд шилжүүлнэ.

8. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь худалдсан, худалдахаар ачуулсан болон ашигласан зэс, зэсийн баяжмалын борлуулалтын үнэлгээнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг борлуулалт, эсхүл ачилт хийснээс хойш 21 хоногийн дотор улсын төсвийн дансанд төлнө.

9. Тусгай зөвшөөрөл эзэмшигч худалдсан, худалдахаар ачуулсан болон ашигласан алт, зэс, зэсийн баяжмалаас бусад ашигт малтмалын борлуулалтад ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг борлуулалт, эсхүл ачилт хийснээс хойш 10 хоногийн дотор тухайн ашигт малтмалын орд байрших орон нутгийн төсвийн дансанд төлнө.

10. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эдэлбэр талбайд орших ашигт малтмалыг гэрээний үндсэн дээр боловсруулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, гадаад дотоодын зах зээл дээр борлуулсан аливаа хуулийн этгээд борлуулсан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төлнө.

11. Энэхүү журмын 10-т заасан хуулийн этгээд нь худалдсан, худалдахаар ачуулсан бүтээгдэхүүнийхээ борлуулалтын үнэлгээнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөө борлуулалт, эсхүл ачилт хийснээс хойш 10 хоногийн дотор тухайн төсөвт төлнө.



12. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн улиралд худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан ашигт малтмалын тоо хэмжээ, борлуулалтын үнэлгээг тооцсон үндэслэл болон ногдуулсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн нийт хэмжээг тусгасан тайлан, мэдээг дараа улирлын эхний сарын 20-ны дотор гарган мэргэжлийн хяналтын болон татварын албанд тус тус хүргүүлнэ.

### Гүрв. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хуваарилах

13. Тухайн сард алт, зэс, зэсийн баяжмалын борлуулалтаас улсын төсөвт төвлөрсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 30 хувийг Сангийн яам дараа сарын 25-ны дотор улсын төсвийн данснаас тухайн ашигт малтмалын орд байршиж байгаа аймаг, нийслэлийн төсвийн дансанд шилжүүлнэ.

14. Тухайн сард алт, зэс, зэсийн баяжмалаас бусад төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнд ногдож, орон нутгийн төсөвт төвлөрсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн 70 хувийг тухайн нутаг дэвсгэрийн төсвийн ерөнхийлөн захирагч дараа сарын 30-ны дотор ашигт малтмалын орд байршиж байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн данснаас улсын төсвийн дансанд шилжүүлнэ.

15. Тухайн сард улсын төсвөөс орон нутгийн төсөвт хуваарилсан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч ашигт малтмалын орд байршиж байгаа сум, дүүргийн төсөвт хуульд заасан хувь хэмжээгээр ажлын 10 хонотг багтаан хуваарилна.

16. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн талбай нь хэд хэдэн аймаг, сумын нутаг дэвсгэрт байршиж байгаа тохиолдолд олборлосон бүтээгдэхүүнд ногдох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хуваарилахдаа тухайн аймаг, суманд орших тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ашиглалт явуулж байгаа эдлэлэр газрын талбайн хэмжээнд үндэслэн тооцно.

17. Аймаг, нийслэлийн төсөвт хуваарилах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь аймаг, нийслэлийн тухайн жилийн төсвийн дүнгээс давсан тохиолдолд давсан хэсгийг улсын төсвөөс аймаг, нийслэлийн төсвийн дансанд шилжүүлэхгүй.

18. Аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүргийн төсвийн дансанд хуваарилах ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн дүн нь сум, дүүргийн тухайн жилийн төсвийн дүнгээс хэтэрсэн тохиолдолд давсан хэсгийг улсын төсөвт буцаан шилжүүлэх бөгөөд өөр сум, дүүргийн төсвийн дансанд шилжүүлэх, зарцуулахыг хориглоно.

### Дөрөв. Зарцуулах

19. Энэхүү журмын 13-18-д заасны дагуу хуваарилагдсан хөрөнгийг хуулийн дагуу төсвийн орлогод бүртгэн, Монгол Улсын Нэгдсэн төсвийн болон Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд заасны дагуу захиран зарцуулна.

### Тав. Хяналт тавих

20. Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч нь улсын төсвөөс орон нутгийн төсөвт, орон нутгийн төсвөөс улсын төсөвт хуваарилж байгаа ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, түүний зарцуулалт холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу хийгдсэн байдалд байнгын хяналт тавьж ажиллана.

21. Төсөвт төвлөрүүлсэн ашигт малтмалын төлбөрийн зарцуулалтад Сангийн яам болон бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч хяналт тавина.

22. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь олборлож худалдсан, худалдахаар ачуулсан болон ашигласан бүтээгдэхүүний тоо хэмжээ, борлуулалтын үнэлгээ болон төсөвт төвлөрүүлэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв тооцож, төсөвт төвлөрүүлсэн байдалд татварын болон мэргэжлийн хяналтын албад тус тус хяналт тавьж ажиллана.

**Засгийн газрын 2006 оны 272 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт**

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТӨЛБӨРИЙГ ТӨЛӨХ, ХУВААРИЛАХ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмын зорилго нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглах тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### Хоёр. Тусгай зөвшөөрлийн төлбөрийг төсөвт төлөх

2. Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн талбайд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрсн олгох тухай шийдвэр гаргасан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан өргөдөл гаргасан этгээдэд тусгай

зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг Ашигт малтмалын тухай хуулийн 34.1-д заасан хугацаанд төлөх талаар мэдэгдэнэ.

3. Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг мэдэгдэл хүлээж авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын валютын дансанд, эсхүл түүнтэй тэнцэх төгрөгийг тухайн өдрийн Монгол банкнаас тогтоосон албан ёсны ханшийг баримтлан төгрөгийн дансанд тус тус төлнө.

4. Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Ашигт малтмалын тухай хуулийн 56.1.2-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцлах тухай шийдвэр гаргаж, өргөдөл гаргасан этгээдэд мэдэгдэнэ.

5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлийн төлбөрийг Ашигт малтмалын тухай хуулийн 32.2, 32.3, 34.2-т заасны дагуу жил бүр төлнө.

6. Тусгай зөвшөөрлийн төлбөр төлсөн өдрийг банкны гүйлгээ хийсэн өдрөөр тооцох бөгөөд холбогдох баримтыг төрийн захиргааны байгууллагад ирүүлснээр тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлсөнд тооцно.

7. Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уг зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг Ашигт малтмалын тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасан нөхцөл, шаардлага, журмын дагуу тусгай зөвшөөрөл эзэмших эрх бүхий бусад этгээдэд шилжүүлсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл шилжүүлэн авсан этгээдийн Ашигт малтмалын тухай хуулийн 32.2, 32.3-т заасан төлбөрийг тодорхойлохдоо урьд ногдуулж байсан төлбөрийг үргэлжлүүлэн тооцож, тусгай зөвшөөрөл шилжүүлсний дараагийн жилээс эхлэн тогтооно.

8. Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь болон тодорхой хэсгийг буцаан өгсөн, эсхүл геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны

байгууллагын шийдвэрээр цуцалсан нь өмнө төлсөн тусгай зөвшөөрлийн төлбөрийг бууруулах, буцаан олгох үндэслэл болохгүй.

9. Төрийн захиргааны байгууллага нь тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг сар бүрийн 25-ны дотор улсын төсвийн орлогын дансанд шилжүүлж, тайланг батлагдсан маягтын дагуу гарган Сангийн яаманд ирүүлнэ.

### **Гурав. Тусгай зөвшөөрлийн төлбөрийг хуваарилах**

10. Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас улсын төсөвт төвлөрүүлсэн тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг Сангийн яам Ашигт малтмалын тухай хуулийн 59.2-т заасан хувь хэмжээгээр тооцож хуваарилна.

11. Сангийн яам нь геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан тухайн аймаг, нийслэлийн төсвийн дансанд шилжүүлнэ.

12. Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч нь тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг Сангийн яамнаас аймаг, нийслэлийн төсөвт шилжүүлсэн өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан сум, дүүргийн төсөвт шилжүүлэх орлогыг хуваарилж, шилжүүлнэ.

### **Дөрөв. Тусгай зөвшөөрлийн төлбөрийг зарцуулах**

13. Тухайн хайгуулын талбай, ашигт малтмалын орд байршиж байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч нь тусгай зөвшөөрлийн төлбөрийг Нэгдсэн төсвийн тухай хуулийн 10.1.6, 10.3.11-д заасны дагуу орон нутгийн төсвийн орлогод бүртгэж, төсвийн санхүүжилтэд зарцуулна.

### **Тав. Тусгай зөвшөөрлийн төлбөрийн тололт, хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих**

14. Тусгай зөвшөөрлийн төлбөрийн тололт, хуваарилалт, зарцуулалтад геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Сангийн яам, аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн ерөнхийлөн захирагч, холбогдох татаарын алба тус тус хяналт тавина.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 280

Улаанбаатар хот

### Төлбөр хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Агуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2. Үйлдвэрлэл, шинжлэх ухааны зориулалтаар барьсан загасны төлбөр болон ахуйн зориулалтаар шувуу агнах, загас барих зөвшөөрлийн хураамжийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авч байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

1. Үйлдвэрлэл, шинжлэх ухааны зориулалтаар барьсан загасны төлбөрийн 1 кг тутамд 1000 /нэг мянган/ төгрөгөөр, ахуйн зориулалтаар шувуу агнах, загас барих зөвшөөрлийн хураамжийг нэг удаагийн эрхийн бичигт 10000 /арван мянган/ төгрөг байхаар тус тус тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БАЙГАЛЬ ОРЧНЫ  
САЙД

И.ЭРДЭНЗБААТАР

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 282

Улаанбаатар хот

### Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Л.Одончимэд, Сангийн сайд Н.Баяртсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

1. Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2006 онд багтаан баталж түүнд тусгагдсан асуудлыг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган, залуучууд, иргэний нийгмийн оролцоотойгоор салбар, орон нутгийнхаа түвшинд хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг жил бүрийн 8 дугаар сард Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд ирүүлж байхыг Засгийн газрын холбогдох гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын нэгдсэн дүнг жил бүрийн Ш улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Л.Одончимэдэд үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1998 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 104 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багцад тусгах, гадаадын зээл, тусламжийн хөрөнгийг ашиглан санхүүжүүлэх замаар хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхсайхан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,  
ХӨДӨЛМӨРИЙН САЙД

Л.ОДОНЧИМЭД

Засгийн газрын 2006 оны 282 дугаар тогтоолын хавсралт

### ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

#### Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын хүн амын насны бүтцийг дэлхийн бусад орны хүн амын насны бүтэцтэй харьцуулахад харьцангуй залууд тооцогдох бөгөөд 2000 оны хүн амын тооллын дүнгээр манай улсын

5 хүн тутмын нэг нь 15-24 насны залуучууд, 2004 оны байдлаар нийт хүн амын 39.5 хувь нь 15-34 насны залуучууд байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1985-1995 оныг Залуучуудын арван жил болгон зарласан бөгөөд 1995 онд НҮБ-аас дэлхийн залуучуудын үйл

ажиллагааны хөтөлбөрийг баталсан нь дэлхий нийтээрээ залуучуудын асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх, тэдний нийгмийн оролцоог дээшлүүлэх боломжийг улам бататгасан юм.

Манай улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орсон шилжилтийн жилүүдэд өсвөр үе, залуучуудыг хөгжүүлэх талаар хэд хэдэн бодлогын баримт бичиг, хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Тухайлбал Монголын залуучуудын үндэсний хөтөлбөр, Залуучуудын хөгжлийн асуудлаар Нэгдсэн Үндэстний Байгууллагатай хамтран ажиллах ойлголцлын санамж бичиг, Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр, "Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого" зэргийг дурдаж болно.

*Монгол Улсын Засгийн газраас 1998 оныг "Залуучуудын", 2002 оныг "Оюутны жил" болгон зарлаж залуучуудын санаачилгыг өрнүүлэхэд ач холбогдол бүхий олон үйл ажиллагааг хэрэгжүүлж багаар амжилтад хүрсэн.*

Мянганы дээд хэмжээний чуулга уулзалтаас 21 дүгээр зуунд дэлхийн улс орнууд хөгжлийн төлөө хамтран ажиллахаар баталсан "Мянганы хөгжлийн зорилтууд"-ын нэлээд нь нийгмийн хөдөлгөч хүч залуусын амьдралтай шууд холбоотой асуудал бөгөөд тэдний идэвхтэй оролцоогүйгээр хэрэгжүүлэх, үр дүнд хүрэх бололцоогүй юм.

Иймд залуучуудын нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлж, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах идэвхтэй иргэн болгон төлөвшүүлэх бодлогыг дэлхий нийтээр баримтлах боллоо. Энэ нь хөгжиж буй улс орны хүн амд залуучуудын эзлэх хувь нэмэгдсэн, дэлхий нийтийн хөгжилд даяарчлалтай холбоотой шинэ нөхцөл байдал бий болж, залуучуудын санаа бодлыг сонсож, шийдвэр гаргах болон хөгжлийн үйл явцад тэдний идэвхтэй санаачилга, дуу хоолой, оролцоог хангах, эрхэд суурилсан хандлагыг хэрэгжүүлэх шаардлага гарч байгаатай холбоотой.

Монголын залуучуудын үндэсний хөтөлбөрийг 1998-2005 онд хоёр үе шаттайгаар хэрэгжүүлсэн бөгөөд хөтөлбөрийн хүрээнд залуучуудын эрүүл мэндийг сайжруулах, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, чөлөөт цагийг зөв боловсон, үр бүтээлтэй өнгөрүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэх, олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвар бүхий мэдлэг, боловсрол эзэмшүүлэх, мэдээллийг цаг үеэсээ хоцролгүй хүртэх боломж нөхцөлийг нэмэгдүүлэх зэрэг арав гаруй багц үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн.

Гэвч хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа дууссан, Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого, Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр зэрэг залуучуудын хөгжлийн асуудлыг хөндсөн бодлого, хөтөлбөр шинээр батлагдсантай холбогдуулан тус

хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах шаардлага гарсан болно.

Хөтөлбөрийн төслийг НҮБ-ын Хүн амын сан, Хүүхдийн сантай хамтран зохион байгуулсан "Өсвөр үе, залуучууд хөгжилд" Үндэсний чуулганаар хэлэлцүүлж, гаргасан саналыг тусгасан болно.

## Хоёр. Хөтөлбөрийн зорилго, хугацаа, зарчим, санхүүжилт

2.1. Хөтөлбөрийн зорилго нь залуучуудын өөрийнхөө төлөө болон нийгмийн төлөө хүлээх хариуцлагыг дээшлүүлэх, хөгжих, эрх ашгаа хамгаалах, нийгэм, улс төр, эдийн засаг, соёлын амьдралд оролцох оролцоог өргөжүүлэх эзлэж орчин бүрдүүлэх замаар чадварлаг, бүтээлч, ёс суртахуунтай, боловсролтой, соёлтой иргэн болж төлөвших, тэдний улс орныхоо хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхэд оршино.

2.2. Хөтөлбөрийг 2015 оныг дуустал дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат:	2007-2008
Хоёрдугаар үе шат:	2009-2012
Гуравдугаар үе шат:	2013-2015

Хөтөлбөрийн үе шат бүрийн төгсгөлд үр дүнгийн үнэлгээ хийж, шаардлагатай бол хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

-Мянганы хөгжлийн зорилт, үндэсний хэмжээний бодлогын баримт бичгийг үйл ажиллагаатай нягт уялдуулна;

-Өсвөр үе, залуучуудын сонголтыг хүндэтгэн, тэднийг хариуцлагатай, бүтээлч иргэн болгон төлөвшүүлэх үйл ажиллагааг дэмжинэ;

-Өсвөр үе, залуучуудад ялгаварлалгүй, тэгш, цогцроор хандах таатай орчин бүрдүүлдэг;

-Үе тэнгийнхэн, гэр бүл, хамт олон, төрийн болон төрийн бус байгууллага, өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, иргэний нийгэм, олон улсын байгууллага, гадаад, дотоодын хандивлагчдын өсвөр үе, залуучуудын төлөөх хүсэл эрмэлзэл, харилцан итгэлцсэн түншлэл, хамтын ажиллагаанд тулгуурлана.

2.4. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

-улс, орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;

-олон улсын байгууллага, хандивлагч орны тусламж, хандив;

-гадаад дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

-бусад эх үүсвэр.

## Гурав. Хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

A. Нийгмийн амьдралд өсвөр үе, залуучуудын оролцоог дээшлүүлэх талаар

Зорилт 3.1. Мэдлэгт тулгуурласан, чанартай боловсрол нь амьжиргааг сайжруулах, зөв дадал, зуршил хэвшүүлэх гол хэрэгсэл гэсэн ойлголт, хандлагыг өсвөр үе, залуучуудад төлөвшүүлэх ээлтэй орчинг бүрдүүлнэ.

3.1.1. "Үе тэнгийн багш" хөдөлгөөнийг өрнүүлж, бичиг үсэг үл мэдэгчдэд зориулсан албан бус сургалтыг өргөжүүлэх;

3.1.2. Үндэсний цөөнх, шилжин суурьшигч, тэнэмэл, ядуу, хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын тусгай хэрэгцээт боловсролын судалгааг хийж, тэдэнд боловсрол эзэмшүүлэх ажлыг олон нийтийн санал санаачилгад тулгуурлан зохион байгуулах;

3.1.3. Боловсролын салбарын жеңдэрийн ялгааг арилгахад чиглэсэн өсвөр үе, залуучуудын санаачилгыг дэмжин ажиллах;

3.1.4. Оюутны дадлага, диплом, курсийн ажил, бүтээлд дэвшүүлсэн оновчтой санаачилгыг дэмжин практикт нэвтрүүлэх чиглэлээр уралдаан зарлах, үзэсгэлэн, яармаг зохион байгуулах үйл ажиллагааг дэмжих;

3.1.5. Гоц авьяастай, оюуны өндөр чадвартай өсвөр үе, залуучуудыг сургах, оюуны бүтээлийг нь дэмжих санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх;

3.1.6. Сургууль завсардсан болон хөдөөгийн өсвөр үе, залуучуудын боломж, нөхцөлд тохирсон зайны, албан бус болон ур чадварын /эрхийн бичгийн/ сургалтыг өргөжүүлэх;

3.1.7. Номын сангийн үйлчилгээг өсвөр үе, залуучуудад ойртуулах, хялбаршуулах, црахим хэлбэрийг нэвтрүүлэх, музей, номын санг тухайн чиглэлийн сургалт, мэдээллийн төв болгох, залуу хүмүүсийг хамруулах талаар олон улсын байгууллага, хандивлагчтай хамтран ажиллах;

3.1.8. Өсвөр үе, залуучуудыг өөрийгөө илэрхийлэх, биеэ зөв авч явах чадвартай болгон төлөвшүүлэх манлайлал, харилцаа, илтгэх ур чадварт суралцуулах иргэний нийгмийн байгууллагын санаачилгыг дэмжих.

Зорилт 3.2. Залуу хүн бүрийг хөдөлмөрийн зах зээлд хөрвөх чадвартай, эдийн засаг, нийгэм, бизнесийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжилтэй боловсон хүчин болгон хөгжүүлэх сургалтын орчинг бүрдүүлнэ.

3.2.1. Залуучуудад мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын үйл ажиллагааг дэмжин дэлгэрүүлэх;

3.2.2. Залуучуудыг мэргэших, давхар мэргэжил эзэмшигчдэд дэмжлэг үзүүлэх;

3.2.3. Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөөс Мэргэжлийн сургалт,

үйлдвэрлэлийн төвд элсэгчдийн хувь, хэмжээг нэмэгдүүлэх замаар нарийн мэргэжлийн ажилтан бэлтгэх, тэдэнд зориулсан ажлын байрыг бий болгох, захиалгаар сургах, энэ чиглэлээр суралцагчдад хөнгөлөлт үзүүлэх, урамшуулах талаар аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан санал санаачилгыг дэмжих;

3.2.4. Улс орны хөгжил, зах зээлд тэргүүлэх ач холбогдол бүхий ажил, мэргэжлээр суралцах залуучуудад хөнгөлөлт үзүүлэх болон ажлын байр, цалин хөлс, нийгмийн баталгаагаар хангах үйл ажиллагааг дэмжих;

3.2.5. Мэргэжлийн боловсрол эзэмшээд мэргэжлээрээ үр бүтээлтэй ажиллаж байгаа залуучуудыг үргэлжлүүлэн сургах, дадлагажуулах талаархи ажил олгогчийн санаачилгыг дэмжих;

3.2.6. Залуучууд ажиллахын зэрэгцээ өөрийн авьяас, сонирхолд тохирсон хэлбэрээр мэргэжлийн боловсрол эзэмших "Олон нийтийн нээлттэй их сургууль" байгуулан ажиллах санал санаачилгыг дэмжих.

Зорилт 3.3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлж, ажилгүйдлийн түвшинг тогтвортой бууруулахад хувь нэмэр оруулна.

3.3.1. Хөдөлмөрийн зах зээлийн байдалд судалгаа хийж түүнийг мэдээлэх цахим хөдөлмөрийн биржийг байгуулан ажиллуулах замаар ажил олгогч хэрэгцээт ажилтныг авах, сул чөлөөтэй ажлын байр зарлах, залуучууд ажил, мэргэжил сонгох боломж, хүртээмжийг бүрдүүлэх;

3.3.2. Оюутан, залуучуудыг богино хугацаагаар болон гэрээгээр, гэрээр ажиллуулах зуучлалын үйлчилгээг өргөжүүлэх, ялангуяа залуучуудын оролцоотой байгуулагдсан хөдөлмөрийн биржийг дэмжих;

3.3.3. Сайн дурын ажил, үйлчилгээг хөгжүүлэх, энэ чиглэлээр ажиллаж байсан залуучуудыг эхний ээлжинд ажлын байраар хангах боломжийг бүрдүүлэх;

3.3.4. Засан хүмүүжүүлэх газраас суллагдсан, тэнэмэл амьдралтай, шилжин суурьшсан, удаан хугацаагаар хөдөлмөр эрхлээгүй "итгэл алдарсан" ажилгүй залуусыг дэмжсэн хөтөлбөр, үйл ажиллагааг дэмжих, тэднийг ажлын байр, орон сууцаар хангасан байгууллага, ажил олгогчийг дэмжин урамшуулах;

3.3.5. Албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа, түүнчлэн хөдөлмөр эрхлээгүй залуучууд хөдөлмөрөө хоршин зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлэх санал санаачилгыг дэмжин, тухайн чиглэлийн мэдээлэлээр хангах;

3.3.6. Хууль бусаар гадаадад зуучлах зэрэг сурталчилгаа, хөдөлмөрийн харилцаан дахь шууд болон шууд бус ялгаварлал, ажлын байран дахь бэлгийн өнгөлзлөг, дарамтлал, нэр хүндэд халдаж байгаа талаархи мэдээллийг нээлттэй болгох, хяналт тавих, улмаар түүнийг

арилгах арга хэмжээг залуучуудын оролцоотойгоор зохион байгуулах;

3.3.7. "Мянганы зам" зэрэг үндэсний болон орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хөдөлмөрийн багтаамж ихтэй ажилд залуучуудын оролцоог хангах.

Зорилт 3.4. Өсвөр үе, залуучуудын онцлог, хэрэгцээнд нийцсэн нийгмийн хамгааллын үйлчилгээг нийгэм, хамт олны оролцоонд тулгуурлан хөгжүүлнэ.

3.4.1. Эрүүл мэндийн болон нийгмийн даатгалд залуусыг бүрэн хамруулах, ялангуяа ажил эрхэлдэггүй, хүнд нөхцөлд амьдардаг залуучуудыг даатгалд хамруулах хөдөлгөөн өрнүүлж мэдээллээр хангах, сурталчилгааг өргөжүүлэх;

3.4.2. Хүнд нөхцөлд амьдарч байгаа өсвөр үе, залуучуудыг нийгэмшүүлэх, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр нийгэм, хамт олонд түшиглэсэн халамж, асрамжийн үйлчилгээг оновчтой, олон нийтэд нээлттэй, үйлчлүүлэгчдэд нийцтэй байдлаар үе тэнгийхэн болон сайн дурынхны оролцоотойгоор зохион байгуулах;

3.4.3. Хүүхдээ асарч байгаа залуу эцэг, эхэд зориулсан халамжийн тусламж, тэтгэмжийг залуучуудад зориулсан хөгжлийн тусламж болгон шинэчлэх талаар холбогдох хууль тогтоомж, хөтөлбөрт өөрчлөлт оруулах асуудлыг судлах;

3.4.4. Гадаадад хөдөлмөр эрхэлж байгаа залуучууд хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд ажиллах, нийгмийн даатгал, хамгааллын үйлчилгээнд хамрагдах асуудлыг шийдвэрлүүлэх.

Зорилт 3.5. Залуучуудын төлбөрийн чадвар, сонирхолд нийцсэн орон сууцаар хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх санал санаачилгыг дэмжих орчинг бүрдүүлнэ.

3.5.1. Залуу гэр бүлийг бие даан амьдрах, орон байртай болоход шаардлагатай мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх үйлчилгээг хөгжүүлэх;

3.5.2. Орон байрны нөхцөлөө сайжруулах талаар техник, санхүүгийн боломж, үр чадвараа нэгтгэн хамтран ажиллах залуучуудын санал санаачилгыг дэмжих талаар нутгийн захиргааны байгууллагын үүрэг, хариуцлагыг сайжруулах;

3.5.3. Хямд төсөр материал ашиглан шинээр орон байр барих, нөхцөлөө сайжруулах талаар залуучуудын гаргасан туршлагыг нэвтрүүлэх ажлыг төрийн бус байгууллагын оролцоотой зохион байгуулах;

3.5.4. Залуучуудыг орон сууцаар хангах, нөхцөлийг нь сайжруулах чиглэлээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, зээл олгох,

хүүгийн хөнгөлөлт үзүүлэх, ипотекийн зээлийн үйлчилгээг хөгжүүлэх;

3.5.5. Хот төлөвлөлт, газар зохион байгуулалт, орон сууцны хороолол дахь дэд бүтцийг сайжруулах, тоглоом, урлаг, спортын талбай байгуулах үйл ажиллагаанд өсвөр үе, залуучуудыг оролцуулах.

Зорилт 3.6. Хөдөөг хөгжүүлэх залуучуудын санал санаачилгыг дэмжих орон нутагтаа үр бүтээлтэй амьдрах орчинг бүрдүүлэх замаар хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжих хөдөлгөөний эрчимжилтийг сааруулна.

3.6.1. Орон нутгийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн "Шинэ үеийн илгээлтийн эзэн" хөдөлгөөнийг өрнүүлэх талаар залуучуудын төрийн бус болон орон нутгийн засаг захиргааны байгууллага хамтран ажиллах;

3.6.2. Орон нутгийн бүтээн байгуулалтад хувь нэмэр оруулж, үр бүтээлтэй ажиллаж байгаа залуучуудыг алдаршуулах, урамшуулах, хөнгөлөлт үзүүлэх журам гарган хэрэгжүүлэх;

3.6.3. Аймаг, сумын Хөдөлмөр эрхлэлтийн алба, төрийн болон төрийн бус байгууллага, сонирхлын бүлгүүдээр дамжуулан залууст бизнес, менежмент, маркетинг, эрх зүй, санхүүгийн анхан шатны боловсрол олгох сургалтыг зохион байгуулах;

Зорилт 3.7. Залуучуудын ядуурлыг бууруулах, амьжиргааг дээшлүүлэх санал санаачилгыг дэмжих таатай орчинг бүрдүүлнэ.

3.7.1. Ядуу байхаас зайлсхийх сэтгэлгээг төлөвшүүлэх, амьжиргааг дээшлүүлэх, амьдралд гарч болох эрсдэлээс хамгаалахад чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, үйл ажиллагааг өсвөр үе, залуучуудын оролцоо, дэмжлэгтэйгээр эрчимжүүлэх;

3.7.2. Амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур түвшинд амьдарч байгаа болон ядууралд өртөж болзошгүй өсвөр үе, залуучуудыг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог дэмжих;

3.7.3. Залуучуудын оролцоотой жижиг болон дунд бизнесийг өргөжүүлэх, "барьцааг орлуулах" системийг судлах, "Нэг суурин-нэг бүтээгдэхүүн" хөдөлгөөнд залуучуудын оролцоог хангах;

3.7.4. Өмч болон эдийн засгийн харилцааны талаархи өсвөр үе, залуучуудын ойлголт, мэдлэгийг сайжруулах, бизнес эрхлэх зөвлөгөө өгөх "Бизнес мэдээллийн төв"-ийг залуучуудын оролцооны байгууллагатай хамтран байгуулах;

3.7.5. Үл хөдлөх хөрөнгийн зуучлалын үйлчилгээг мэдээллийн шинэ технологи ашиглан шуурхай үзүүлэх арга хэлбэрийг дэмжих;



3.7.6. Залуучууд, оюутны хотхонд хүүхдийн цэцэрлэг, худалдаа, үйлчилгээ, интернет кафе, шуудангийн болон ахуйн үйлчилгээ эрхлэх санал санаачилгыг дэмжих;

3.7.7. Бичил аж ахуйн нэгжийн чадавхийг бэхжүүлэх хүрээнд бизнес инкубаторын үйл ажиллагааг залуучуудад сурталчлах.

Зорилт 3.8. Залуу гэр бүлд амьжиргаагаа дээшлүүлэх, хүүхдээ хүмүүжүүлж хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг тэдний оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.

3.8.1. Гэр бүлийн хөгжлийн төвийг байгуулан ажиллуулах санал санаачилгыг дэмжин түүний үйлчилгээнд залуу гэр бүлийг хамруулах, өсвөр үе, залуучуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх асуудлаар зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлэх;

3.8.2. Гэр бүл болсон залуучуудад бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх урт хугацааны зээл, лизингийн үйлчилгээг өргөжүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагыг дэмжих;

3.8.3. Залуучуудын дунд өсөн нэмэгдэж байгаа гэр бүлийн "хамтран амьдрах" хэлбэрийг холбогдох хууль тогтоомжид тусгах, хамтын хариуцлагыг өндөржүүлэх;

3.8.4. Залуу гэр бүлийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудалд онцгой анхаарал хандуулж, хүүхэдтэй байхыг дэмжих эдийн засгийн механизм бий болгох.

Зорилт 3.9. Өсвөр үе, залуучууд, ахмад үеийнхний залгамж холбоог бэхжүүлэх санал санаачилгыг хөхиүлэн дэмжинэ.

3.9.1. Өсвөр үе, залуучуудыг амьдралд бэлтгэхэд ахмад үе, эцэг, эхийн оролцоог чухалчлах;

3.9.2. Өсвөр үе, залуучуудыг удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх талаар мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлэх;

3.9.3. Байгаль орчныг хамгаалах ардын зан үйлийг залууст төлөвшүүлэх санаачилгыг дэмжих;

3.9.4. Эцэг эх, үр хүүхдийн хоорондын харилцааг нээлттэй байлгаж, ялангуяа эцгийн үлгэр дууриаллыг нэмэгдүүлэх талаархи орчин үеийн хандлагыг төлөвшүүлэх;

3.9.5. Малчин залуучуудыг амьдрах ухаан, мал маллах арга ажиллагаанд сургах үйл ажиллагааг дэмжих.

Зорилт 3.10. Өсвөр үе, залуучуудын авьяас чадварыг дэмжин, соёл урлаг, спортын арга хэмжээнд оролцох, түүх, соёл, уламжлалт зан заншлаа хамгаалан хөгжүүлэхэд оролцох боломжийг өргөжүүлнэ.

3.10.1 Бүх шатны сургууль, аж ахуйн нэгжээс зохион байгуулж байгаа урлаг соёл, спортын арга хэмжээнд өсвөр үе, залуучууд

оролцох, эдгээр арга хэмжээг залуучуудын зүгээс зохион байгуулахыг дэмжих;

3.10.2 Түүх, соёлын өвөө хамгаалах, эх оронч үзэл, уламжлалт зан үйлийг хөгжүүлэхэд өсвөр үе, залуучуудын оролцоог хангах;

3.10.3 Ардын урлаг, уламжлалт тоглоом, наадагйг хөгжүүлэх хөдөлгөөн өрнүүлэхэд залуучуудын оролцоог хангах;

3.10.4 Өсвөр үе, залуучууд, оюутны спорт, урлагийн наадмыг зохион байгуулах залуучуудын санал санаачилгыг дэмжих.

Б. Өсвөр үе, залуучуудад хорт зуршил, өвчлөлөөс сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэх талаар /эрүүл залуу үе/

Зорилт 3.11. Өсвөр үе, залуучуудыг ариун цэвэр болон эрүүл ахуйн зөв дадал хэвшилд сургах, аливаа өвчнөөс сэргийлэх, эрүүл хооллох, эрүүл мэндээ хамгаалах залуучуудын мэдлэгийг дээшлүүлнэ.

3.11.1. Хамт олон, суралцагчид, ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, өсвөр үе, залуучуудад ээлтэй эрүүл орчинг бүрдүүлэх талаар "Эрүүл мэндийг дэмжигч байгууллага" болох хөдөлгөөнийг өргөжүүлэх;

3.11.2. Осол гэмтлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах чиглэлээр мэдлэг олгох сургалтыг сургууль, байгууллага, хамт олон, өсвөр үе, залуучуудын дунд явуулах, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах;

3.11.3. Урлаг, биеийн тамир, спортын цогцолбор, цэнгэлдэх хүрээлэн зэрэг өсвөр үе, залуучууд олноор цуглардаг үйлчилгээний газарт гарч болошгүй осол, аюулаас сэргийлэх санамж, зааварчилгаа байрлуулах, зөв хооллох, амрах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох сурталчилгааны материалыг боловсруулан түгээх;

3.11.4. Бүх шатны сургуулийн сургалтын хөтөлбөрийн эрүүл мэндийн боловсрол олгох хичээлийн үр нөлөөнд үнэлгээ хийж, боловсронгуй болгох арга хэмжээг өсвөр үе, залуучууд, эцэг, эх, сурган хүмүүжүүлэгч, сургуулийн удирдлагын оролцоотойгоор хэрэгжүүлэх;

3.11.5. Байгалийн гаралтай илчлэг ихтэй, иод болон амин дэмээр баалаг хүнсний бүтээгдэхүүнийг өргөн хэрэглэх дадал хөшлийг төлөвшүүлэхэд өсвөр үе, залуучуудын оролцоог хангах;

3.11.6. Өсвөр үе, залуучуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд сайн дураараа жилд 1-ээс доошгүй удаа орох дадлыг хэвшүүлэх.

Зорилт 3.12. Залуучуудад эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааг хөгжүүлнэ.

3.12.1. Өсвөр үе, залуучуудад эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэвлэл, мэдээллийн хэрэгслийн нийтлэл, нэвтрүүлгийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгах, нийгмийн эрүүл мэнд, нийтийн биеийн тамирыг сурталчилсан сувгийг ажиллуулах арга хэмжээ авах;

3.12.2. Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажилд байгууллага, хамт олон, залуучуудын идэвхтэй оролцох боломжийг бүрдүүлж явган аялал, зугаалга, биеийн тамирын уралдаан тэмцээн, бүх нийтийн спортын арга хэмжээг хөхиүлэн дэмжих;

3.12.3. Биеийн тамир, спорт, амралт, алжаал тайлах, бялдаржуулалт, бясалгалын төв зэрэг өсвөр үе, залуучуудын бие бялдар, сэтгэхүйг хөгжүүлэх үйлчилгээг хөнгөлөлттэй нөхцөлөөр үзүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

3.12.4. Өсвөр үе, залуучуудын нас баралтын зонхилох шалтгаан болох осол, гэмтлээс сэргийлж, замын хөдөлгөөн, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаархи зөв хандлагыг төлөвшүүлэх сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх;

3.12.5. Өсвөр үе, залуучууд өөрийгөө хамгаалах мэдлэг, ур чадвартай болох, сэтгэцийн болон бусад зөвлөгөө, үйлчилгээ өгөх ээлтэй, тохиромжтой нөхцөлийг бүрдүүлэх талаархи санал санаачилгыг дэмжих.

Зорилт 3.13. Халдварт өвчин, түүний дотор бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ, сүрьеэ зэрэг өвчнөөс өөрийгөө болон бусдыг сэргийлэх зан үйлийг залуучуудад төлөвшүүлнэ.

3.13.1. Өсвөр үе, залуучуудын дунд нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндийн хэрэгцээ, хандлага, өөрчлөлтийн асуудлаар судалгаа хийх;

3.13.2. Бүх шатны сургууль, зэвсэгт хүчний болон хилийн цэргийн ангиуд зэрэг залуучууд олноор ажиллаж, сурдаг байгууллага, аж ахуйн нэгжид орон тооны эмч ажиллуулах, ХДХВ/ДОХ-ын талаар сургалт явуулах, өсвөр үе, залуучуудад ээлтэй нөхөн үржихүйн эрүүл мэндийн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлэх, чадавхийг бүрдүүлэх;

3.13.3. Хөгжлийн бэрхшээлтэй өсвөр үе, залуучуудын эрүүл мэндийн тусгай хэрэгцээг хангах нийгэм, хамт олонд түшиглэсэн нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйлчилгээг өргөжүүлэх;

3.13.4. Өндөр эрсдэлтэй эмзэг бүлгийн өсвөр үе, залуучууд, түүний дотор биеэ үнэлэгч, бэлгийн цөөнх, ажил, сургуульгүй, орлогогүй залууст БЗДХ/ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх, эрсдэлгүй зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, ХДХВ-ийн нэр хаяггүй сайн дурын шинжилгээ, бэлгийн эрүүл мэндийн

зөвлөгөө авах үйлчилгээг зохион байгуулах санаачилгыг дэмжих;

3.13.5. ХДХВ/ДОХ-той өсвөр үе, залуучуудын эрхийг хамгаалах, нууцыг хадгалах, ялгаварлан гадуурхахгүй байх, нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө өгөх, эмчлэх ээлтэй орчинг бүрдүүлэх;

3.13.6. ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх, асран халамжлах үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлж дүгнэхэд залуучууд, ялангуяа ХДХВ/ДОХ-той өсвөр үе, залуучуудыг өргөнөөр оролцуулах;

3.13.7. Өсвөр үеийнхний бэлгийн харьцаанд эрт орохоос сэргийлэх, залуучуудад бэлгийн замаар дамжих халдвар болон ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх "ABCD" зарчмыг дэмжих.

Зорилт 3.14. Өсвөр үе, залуучуудын нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг боловсролыг нэмэгдүүлж, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх, эрсдэлгүй зан үйлийг төлөвшүүлэх.

3.14.1. Өсвөр үе, залуучуудын дунд нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх;

3.14.2. Хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлт, эрт төрөлтөөс сэргийлэх мэдлэг, зан үйлийг өсвөр үе, залуучуудад төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх;

3.14.3. Эмзэг бүлгийн хүмүүсийг жирэмслэлтээс хамгаалах стандартын шаардлага хангасан, хямд, олдоцтой хэрэгслээр хангах, хэрэглэж сургах талаар залуучуудад ээлтэй нөхөн үржихүйн эрүүл мэндийн суурь үйлчилгээ үзүүлэх төвүүдийн үйл ажиллагааг хүртээмжтэй болгох;

3.14.4. Өсвөр үе, залуучуудын нас, хүйс, сэтгэхүйн онцлогт тохирсон гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн зөв хандлага, нийтийг хамарсан ойлголтыг төлөвшүүлэх үйл ажиллагааг өргөжүүлэх.

Зорилт 3.15. Архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, иргэний нийгэм, өсвөр үе, залуучуудын оролцоог хангана.

3.15.1. Нийтээр тэмдэглэх баяр, ёслолын өдрүүдийг архи, тамхигүй зөв боловсон өнгөрүүлэх, архи, тамхины хэрэглээг бууруулах, мансууруулах бодисын хэрэглээ нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх талаар идэвхтэй ажиллаж байгаа байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх;

3.15.2. Архидан согтуурах, тамхины хор хөнөөлөөс сэргийлэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд өсвөр үе, залуучууд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хяналтыг өндөржүүлэх;

3.15.3. Архи, тамхи, мансууруулах бодисын хор уршгийг өсвөр үе, залуучууд эцэг, эх, хамт олонд ойлгуулах, зөв хандлага

төлөвшүүлэхэд чиглэсэн бүх төрлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх;

3.15.4. Мансууруулах бодис, архи, тамхийг тохиолдлын чанартай хэрэглэх, хэрэглэж эхлэхээс урьдчилан сэргийлэх зан үйлийг төлөвшүүлэх;

3.15.5. Архи, тамхи, мансууруулах бодист донтсон залуучуудыг эмчлэх, нөхөн сэргээх, хор нөлөөг бууруулах үйлчилгээг хувийн хэвшлийн, төрийн бус байгууллагын оролцоотойгоор хөгжүүлэх;

3.15.6. Мансууруулах бодис агуулдаг, сэтгэцийн үйл ажиллагаанд нөлөөлдөг эмийн борлуулалтад хяналт тавих;

3.15.7. Мансууруулах бодис сурталчилж байгаа хууль бус үйл ажиллагаанд хяналт тавихад иргэний нийгэм, өсвөр үе, залуучуудын оролцоог хангах;

3.15.8. Өсвөр үе, залуучуудыг хорт зуршлаас сэргийлэх чиглэлээр үе тэнгийн сургагч бэлтгэх үйл ажиллагааг тасралтгүй дэмжин өргөжүүлэх.

**В. Аюулгүй орчинг бүрдүүлэхэд өсвөр үе, залуучуудын оролцоо**

Зорилт 3.16. Экологийн мэдлэгийг өсвөр үе, залуучуудад төлөвшүүлж, тэдний оролцоотой байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх таатай орчинг бүрдүүлнэ.

3.16.1. Гол горхины эх, баталгаат ундны усыг хамгаалах, зохистой хэрэглээний талаар гаргасан өсвөр үе, залуучуудын санал санаачилгыг нутгийн захиргааны байгууллагаас дэмжин хамтран ажиллах;

3.16.2. Байгаль орчныг хамгаалах, эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, экологийн боловсрол олгох талаархи мэдээлэл, сурталчилгааг өсвөр үе, залуучуудын оролцоотой зохион байгуулах, хялбаршуулсан ухуулга, сурталчилгааны материалыг түгээх талаархи хэвлэл, мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Зорилт 3.17. Гэмт хэрэг, зөрчилгүй тайван орчныг бүрдүүлэх талаар өсвөр үе, залуучуудын санал санаачилгыг дэмжин холбогдох байгууллагатай хамтран ажиллана.

3.17.1. Өсвөр үе, залуучуудыг гэмт хэрэгт орохоос урьдчилан сэргийлэх ажлыг хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн оролцоотой өргөжүүлэх;

3.17.2. Бүх шатны сургуульд суралцагсдын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх арга хэмжээг өсвөр үе, залуучуудын оролцоонд тулгуурлан зохион байгуулах талаархи иргэний нийгмийн байгууллагын санаачилгыг дэмжин хамтран ажиллах;

3.17.3. Тэнэмэл хүүхдийг нийгэмшүүлэх хөтөлбөрийг боловсруулан

хэрэгжүүлэх ажилд сайн дурынхан, нийгмийн ажилтантай хамтран ажиллах талаар аж ахуйн нэгж, байгууллагын санал санаачилгыг дэмжих;

3.17.4. Гэмт хэрэг, зөрчилд орж болзошгүй хүүхэд, залуучуудын судалгааг нутгийн захиргааны байгууллага, иргэний нийгмийн оролцоотой гаргаж тэдний зан үйлийг өөрчлөх сургалт, сурталчилгааг өргөжүүлэх;

3.17.5. Зөрчилтэй гэр бүлд амьдардаг өсвөр үе, залуучуудад зориулан хамтран бэрхшээлээ туулах, сэтгэл санаагаа хуваалцах бүлгийн уулзалт, чөлөөт ярилцлага зохион байгуулдаг клубийг иргэний нийгмийн оролцоотой байгуулан ажиллуулах;

3.17.6. Нийгмийн бүх түвшинд харилцааны эрүүл орчинг бүрдүүлэхэд иргэний нийгмийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх.

Зорилт 3.18. Гэмт хэрэгт өртсөн өсвөр үе, залуучуудыг нийгэмшүүлэх, тэдэнд туслха, нөхөн сэргээх ажлыг хувийн хэвшил, иргэний нийгэм, залуучуудын дэмжлэгтэйгээр зохион байгуулна.

3.18.1. Хорих болон засан хүмүүжүүлэх байгууллагад хоригдож байгаа өсвөр үе, залуучуудад зориулсан сэтгэл заслын үйлчилгээ, соёл, спорт, хүмүүжлийн арга хэмжээг өсвөр үе, залуучуудын төрийн бус болон холбогдох мэргэжлийн байгууллагын оролцоотой зохион байгуулж байх;

3.18.2. Гэмт хэрэгт өртөж нийгмээс тусгаарлагдсан хүүхэд, залуучуудад боловсрол, мэргэжил олгох, хорих байгууллагаас суллагдах үед ажлын байраар хангах талаар бүх хэвшлийн байгууллагаас гаргасан санаачилгыг дэмжих;

3.18.3. Өсвөр үе, залуучуудын эрхийг хамгаалах, хорих байгууллагын үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагаас хяналт тавих боломжийг өргөжүүлэх;

3.18.4. Өсвөр үе, залуучуудыг боловсрол зээмших, гэрээгээр /захиалгаар/ аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхлэх боломж олгох талаар хууль тогтоомжид зохих өөрчлөлт оруулах асуудлыг судлах, ийм санаачилга гаргаж байгаа байгууллагын үйл ажиллагааг дэмжин ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

Зорилт 3.19. Өсвөр үе, залуучуудыг аливаа хүчирхийлээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлийг өөрчлөх таатай орчинг бүрдүүлнэ.

3.19.1. Өсвөр үе, залуучууд бие биенээ хүйс, хөрөнгө чинээ, эрүүл мэндийн байдал, яс үндсээр нь ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хүмүүжлийн ажлыг өргөжүүлэх, энэ талаархи иргэний нийгмийн байгууллагын санал санаачилгыг дэмжих;

3.19.2. Бүхмидэх, хүчирхийлэл үйлдэх, амиа егүүтгэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ухуулга сурталчилгааг өргөжүүлж, хялбаршуулсан гарын авлага материалыг түгээх.

3.19.3. Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялангуяа бэлгийн зорилгоор ашиглах, хил давуулан худалдахаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх үйлчилгээг өсвөр үе, залуучуудын оролцоотойгоор зохион байгуулах;

3.19.4. Хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд иргэний нийгэм, хувийн хэвшил, хууль хяналтын байгууллагын оролцоог хангах талаар хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж түүний хэрэгжилтэд өсвөр үе, залуучуудын хяналт тавих боломжийг өргөжүүлэх талаар арга хэмжээ авах;

3.19.5. Хүүхэд, эмэгтэйчүүдийг хил давуулан худалдаалах явдалтай тэмцэх ажилд өсвөр үе, залуучуудыг оролцуулан, ялангуяа зуучлагч, худалдаалагчдын талаархи мэдээллийг олж авахад тэдэнтэй хамтран ажиллах.

Зорилт 3.20. Хүний эрхийг хангах үйл ажиллагаанд өсвөр үе, залуучуудын оролцох боломжийг өргөжүүлэх, дэмжлэг үзүүлэх эдийн засаг, нийгмийн таатай орчинг бүрдүүлнэ.

3.20.1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон холбогдох бусад олон улсын гэрээ болон Монгол Улсын хууль тогтоомжид хүний эрхийн талаар заасан ойлголт, мэдлэгийг сайжруулахад чиглэсэн сургалт, сурталчилгааг өсвөр үе, залуучуудын дунд өргөжүүлэх;

3.20.2. Өсвөр үе, залуучуудын боломж, хэрэгцээнд нийцсэн хууль зүйн тусламж, үйлчилгээ авах, бусдаас хамааралгүйгээр эзлэж нөхцөлд мэдүүлэг өгөх боломжийг бүрдүүлэх;

3.20.3. Өсвөр үе, залуучуудын соёл, боловсрол, иргэний үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх ажлыг иргэний нийгмийн оролцоотой зохион байгуулах;

3.20.4. Сайн засаглалыг хөгжүүлэх, авилгалтай тэмцэх, түүнийг бууруулах үйл ажиллагаанд өсвөр үе, залуучуудыг оролцуулах.

## Г. Даяарчлал болон өсвөр үе, залуучуудын талаар

Зорилт 3.21. Мянганы хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд өсвөр үе, залуучуудын оролцоог нэмэгдүүлж, даяарчлалын үйл явцыг улс орны хөгжилд нааштайгаар ашиглах таатай орчинг бүрдүүлнэ.

3.21.1. Хөгжлийн албан ёсны туслалцаа, техникийн хамтын ажиллагааны хүрээнд өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах;

3.21.2. Залуу хүн бүр гадаад хэлийг сурах хөдөлгөөн өрнүүлэх;

3.21.3. Гадаад орны тэргүүний техник, технологи, "ноу-хау" авч ашиглах, үндэсний технологи бий болгон эзэмших өсвөр үе, залуучуудын идэвх санаачилгыг дэмжих.

Зорилт 3.22. Өсвөр үе, залуучуудын байгууллага хоорондын олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.

3.22.1. Өсвөр үе, залуучуудын төлөөллийн байгууллагаас гадаад харилцаагаа өргөжүүлэх талаархи санал, санаачилгыг төрөөс дэмжин, хамтран ажиллах;

3.22.2. Өсвөр үе, залуучуудын асуудлаар дэлхийн болон олон улсын хэмжээнд болсон хурал чуулганы шийдвэрийг сурталчлах, зохион байгуулагдах арга хэмжээнд өсвөр үе, залуучуудын төлөөллийг оролцуулж байх;

3.22.3. Гадаад оронд Монгол Улсын нэр хүндийг хамгаалан, хууль ёсыг дээдлэн соёлтой ажиллаж амьдрах, зорчих, тухайн улс орны дэвшилтэт хөгжлөөс суралцан эх орондоо түгээн дэлгэрүүлэх талаар өсвөр үе, залуучуудад зориулсан ухуулга, сурталчилгааны ажлыг хэвлэл, мэдээллийн байгууллагын дэмжлэгтэйгээр зохион байгуулах;

3.22.4. Олон улсын байдлыг ойлгон мэдэрч ардчиллын үнэт зүйлс, нийгмийн шударга ёс, үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах хувь хүний итгэл үнэмшилгүй төлөвшүүлэх талаархи өсвөр үе, залуучуудын төлөөллийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих.

Зорилт 3.23. Монгол орны онцлог, нөхцөл байдалд тохирсон мэдээлэл харилцааны технологийг хөгжүүлэхэд өсвөр үе, залуучуудын оролцоог хангана.

3.23.1. Өөрийн орны онцлогт тохирсон e-арилжаа, e-үйлчилгээг хөгжүүлэхэд өсвөр үе, залуучуудыг, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй, ядуу, хүнд нөхцөлд байгаа болон алслагдсан нутгийн залуучуудыг оролцуулах, мэдээлэл, технологийн үр ашгаас хүртэж чадавхиа бэхжүүлэх боломжийг нэмэгдүүлэх талаар сурталчилгаа хийх;

3.23.2. Мэдээлэл харилцааны шинэ технологи, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн, загварын үйлдвэрлэлийг бий болгож байгаа үндэсний үйлдвэрлэгчдэд хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх замаар залуучуудад мэдээллийн шуурхай, хямд үйлчилгээг хүртээмжтэй болгох.

Зорилт 3.24. Монголын өсвөр үе, залуучууд дэлхий дахинд нүүрлэж байгаа терроризмын аюул заналаас урьдчилан сэргийлэх талаар бусад орны өсвөр үе, залуучуудтай хамт даян дэлхийд энх амгалан байдлыг тогтооход хувь нэмэр оруулна.

3.24.1. Терроризмын хор уршиг, аюулт үр дагаврыг нийт иргэдэд ойлгуулан болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, сонор сэрэмжтэй амьдрах дадал, хэвшилтэй болгоход залуучуудын оролцоог нэмэгдүүлэх;

3.24.2. Цэргийн насны залуучуудыг цэргийн алба хаах нь эх орныхоо тусгаар тогтнолыг хамгаалах, дэлхийн энхийг сахиулах үйл хэрэгт оруулж байгаа хувь нэмэр болох

талаархи сурталчилгааг залуучуудын дунд өргөжүүлэх;

3.24.3. Хугацаат цэргийн алба хааж байгаа залуучууд болон цэргийн албан хаагчдын дунд хүчирхийллийн эсрэг хандлага төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулахыг дэмжих;

3.24.4. Шашин шүтлэг, арьс үндсээр ялгаварлан гадуурхах байдлаас үүсч болзошгүй зөрчилдөөн, терроризмын аливаа үйлдэл гарахаас урьдчилан сэргийлэх ажилд үе тэнгийхэн, иргэний нийгмийн оролцоог хангах.

## Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

4.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, мэдээллээр хангах, хяналт тавих, жил бүр хэрэгжилтийн явцыг гаргаж Засгийн газарт тайлагнах үүргийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам хариуцна.

4.2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд салбар дундын зохицуулалт хийх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүргийг Хүн амын хөгжлийн асуудлаархи үндэсний хороо гүйцэтгэнэ.

4.3. Урдан нутагт хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохицуулах, хяналт тавих үүргийг бүх шатны Засаг дарга хариуцан зохион байгуулна.

4.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд байгууллага, аж ахуйн нэгж, иргэд дараахь байдлаар оролцно:

### I. Бүх шатны төрийн захиргааны байгууллага:

4.4.1. Өсвөр үе, залуучуудын эрэлт хэрэгцээ, эрх ашгийг нь хамгаалах чиглэлээр холбогдох Олон улсын гэрээ, конвенцид нэгдэх, үндэсний хууль тогтоомж, хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах, хэрэгжүүлэх асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газарт асуудал боловсруулан оруулж шийдвэрлүүлэх, шаардлагатай хөрөнгийг бүрдүүлэх;

4.4.2. Хөтөлбөрт тусгасан асуудлыг салбарын бодлогод тусган хэрэгжүүлэх, өсвөр үе, залуучуудыг дэмжих талаар шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчдын чадавхийг бэхжүүлэх;

4.4.3. Хөтөлбөрийн асуудлаар байгууллага, аж ахуйн нэгжийг удирдаж, чиглэлээр хангах;

4.4.4. Иргэний нийгэм, төрийн бус байгууллагаас өсвөр үе, залуучуудын асуудлаар ирүүлсэн санал санаачилгыг судлан, төрийн гүйцэтгэх зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх болон хамтран ажиллах;

4.4.5. Өсвөр үе, залуучуудын асуудлаархи олон улсын гэрээ, конвенц, хурал

зөвлөгөөний шийдвэр, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд залуучууд, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан хяналт-үнэлгээ хийх;

4.4.6. Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгэм, олон нийтийг мэдээллээр хангах, тэдний саналыг үйл ажиллагаандаа тусгах.

### II. Төрийн бус байгууллага

4.4.7. Өсвөр үе, залуучуудын хэрэгцээнд тохирсон үйл ажиллагаа явуулах эрмэлзэл, манлайллыг хөгжүүлэх, зөвлөн туслах үйлчилгээг зохион байгуулах;

4.4.8. Хөтөлбөрийн хэрэгжилтэд өсвөр үе, залуучуудын оролцоог хангах, хэрэгцээ, санал бодлыг төрийн байгууллагад хүргэх;

4.4.9. Хөгжлийн бэрхшээлтэй, тэнэмэл, ядуу, хүнд нөхцөлд амьдардаг өсвөр үе, залуучуудыг нийгмийн идэвхтэй гишүүн болгоход чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах;

4.4.10. Хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, түүнд хяналт тавих чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажиллах;

4.4.11. Хөтөлбөрийн холбогдох асуудлаар төсөл боловсруулан төрийн болон олон улсын байгууллага, хандивлагчдад хандах, хөрөнгө, нөөцийг дайрлах;

4.4.12. Өсвөр үе, залуучуудын эрх ашигтай холбоотой асуудлаар санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, нийгмийн амьдралд залуучуудын оролцоо эрхийг хүндэтгэх, оролцоог дээшлүүлэх зорилгоор үндэсний, бүсийн хэмжээний хурал зөвлөгөөн зохион байгуулах, үндэсний хэмжээний болон олон улсын хурал зөвлөгөөн, сургалтад зохих төлөөллийг оролцуулж байх;

4.4.13. Өсвөр үе, залуучуудын асуудлаар үйл ажиллагаа явуулдаг иргэн, байгууллагын чадавхийг бэхжүүлэх дэмжлэг үзүүлэх;

4.4.14. Өсвөр үе, залуучуудад зориулсан урлаг, спорт зэрэг арга хэмжээг зохион байгуулах.

### III. Хувийн хэвшил

4.4.15. Өсвөр үе, залуучуудын чиглэлээр зохион байгуулж байгаа зарим арга хэмжээг санхүүжүүлэх, дэмжлэг үзүүлэх;

4.4.16. Залуучуудад зориулсан урлаг, спорт зэрэг арга хэмжээ зохион байгуулах, тэдний тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

4.4.17. Өсвөр үе, залуучуудад ээлтэй эрүүл ажлын байрыг бий болгох санаачилга гаргах.

## IV. Хэвлэл мэдээллийн байгууллага

4.4.18. Өсвөр үе, залуучуудын талаар баримталж байгаа бодлого, арга хэмжээг сурталчлах, ил тод байдлыг хангах;

4.4.19. Залуучуудын хэрэгцээнд тулгуурласан нийтлэлийн бодлогыг хэрэгжүүлэх, тэднийг хөгжүүлэх, өв тэгш хүмүүжүүлэхэд чиглэгдсэн, өдөр тутмын хэрэгцээт мэдээллийг олон нийтэд хүргэх;

4.4.20. Өсвөр үе, залуучуудын хэрэгцээ, санал бодлыг хэвлэл мэдээллээр дамжуулан холбогдох байгууллагад хүргэх;

4.4.21. Олон улсын хэмжээний хурал зөвлөгөөн, төр, засгийн бодлого, шийдвэрийн талаар сурталчлах, түүний хэрэгжилтийн байдалд хяналт тавих, иргэдийн санал бодлыг тусгах;

4.4.22. Өсвөр үе, залуучуудын онцлог, хэрэгцээ, байдлын талаархи олон нийтийн ойлголт, хандлагыг өөрчлөх мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах.

## V. Сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллага

4.4.23. Өсвөр үе, залуучуудын онцлог, тулгамдсан асуудлыг судлан, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох;

4.4.24. Хөтөлбөрийн талаархи мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулж байх;

4.4.25. Холбогдох байгууллагын захиалгын дагуу өсвөр үе, залуучуудын асуудлаар судалгаа хийж, бодлогын зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллагад хүргэх;

4.4.26. Өсвөр үе, залуучуудын асуудлаар эрдэм шинжилгээний ажлыг өргөжүүлэх;

4.4.27. Шинжлэх ухаан, технологийн сангаас болон төрийн захиалгаар залуу эрдэмтэн судлаачид, оюутнуудын хийсэн судалгаа, шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг бизнесийн байгууллагад сурталчлах, үйлдвэрлэгчдэд борлуулах, гэрээний үндсэн дээр шилжүүлэх ажлыг холбогдох яамд Шинжлэх ухаан, технологийн сантай хамтран зохион байгуулах;

4.4.28. Өсвөр үе, залуучуудын төлөө ажилладаг мэргэжилтэн, сэтгүүлчид, судлаач, хуульчийг бэлтгэх, чадавхийг нь бэхжүүлэх, давтан сургах ажлыг төр, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулах.

## VI. Өсвөр үе, залуучууд

4.4.29. Олж авсан мэдлэг, мэдээллээ баталгаажуулах, амьдралдаа хэрэглэх үр чадвар эзэмших;

4.4.30. Найдвартай, идэвхтэй оролцогч байх хүсэл, эрмэлзлээ илэрхийлэх;

4.4.31. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр санал бодлоо илэрхийлэх, ардчилсан дирддлага, өөрийгөө илэрхийлэх чадварт суралцах;

4.4.32. Байгууллага, аж ахуйн нэгжээс зохион байгуулж байгаа арга хэмжээнд оролцох, мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмж, заавар, мэдээллийг хэрэгжүүлэх, бусдадаа үлгэр дууриал болж байх;

4.4.33. Өсвөр үе, залуучуудад сөргөөр нөлөөлж байгаа зар сурталчилгаа, зуучлалд хяналт тавих, холбогдох байгууллагад мэдээлэхэд оролцож байх;

4.4.34. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, төлөөллийн байгууллагатайгаа нягт хамтран ажиллах.

## Тав. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтэд үе шат бүрээр дараахь үзүүлэлтийг үндэслэн хяналт-шинжилгээ хийнэ:

### A. Статистик мэдээлэл

5.1.1. Бүх шатны боловсролд хамрагдагсдын хүйсийн харьцааны үзүүлэлт;

5.1.2. 10-15 насны хүүхдийн сургууль завсардалтын хувь;

5.1.3. 19-35 насны хүн амын ажилгүйдлийн болон ажил эрхлэлтийн түвшин;

5.1.4. 18-35 насны хүн амын нийгмийн даатгалд хамрагдалт;

5.1.5. 15-17 насны охидын төрөлтийн хувь;

5.1.6. Зонхилон тохиолдох өвчин, ялангуяа осол гэмтэл, хорт зуршлаас үүдэлтэй өвчлөл, нас баралтын түвшин;

5.1.7. 18-35 насны залуучуудын үйлдсэн гэмт хэргийн тоо.

### Б. Байгууллагын дотоод мэдээлэл, үйл ажиллагааны тайлан

5.1.8. Орон сууцны зээлд залуучууд хамрагдсан байдал;

5.1.9. Өсвөр үе, залуучуудын үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ;

5.1.10. Хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг тухайн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрт тусгасан байдал;

5.1.11. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд хамтран ажилласан байгууллагын тоо;

5.1.12. Хамтран ажилласан байгууллагаас зарцуулсан хөрөнгийн хэмжээ.

### В. Түүвэр судалгаа

5.1.13. Залуучуудын ядуурлын байдал;

5.1.14. Нөхөн үржихүйн эрүүл мэнд, Бэлгийн замын халдварт өвчин, ХДХВ/ДОХ-ын талаархи мэдлэг хандлага;

5.1.15. Жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх хэрэгслийн хэрэглээ;

5.1.16. Архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээ;

5.1.17. Өсвөр үе, залуучуудын амьдралын хэвшил, хэрэглээнд гарч байгаа өөрчлөлтийн хандлага.

5.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг хүн амын

бодлогын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж эрхлэн гүйцэтгэнэ.

5.3. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилд иргэний нийгэм, ялангуяа өсвөр үе, залуучуудын оролцоог хангах боломжийг бүрдүүлнэ.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2006 оны 12 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2, 111.5 заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим  
13.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүн Н.Жанцан, Ч.Дашням /илтгэгч/, Д.Наранчимэг, Ц.Сарантуяа нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргагч Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар багт оршин суух, иргэн Н.Идэр, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Шаравдорж нар оролцов.

**Нэг. Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар багт оршин суух, иргэн Н.Идэр Үндсэн хуулийн цэцэд 2006 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр ирүүлсэн өргөдөлдөө:**

"Монгол Улсын Үндсэн хууль нь бусад хуулийн үндсэн эх сурвалж, толгой хууль болж байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт зааснаар "гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно" гэж заажээ.

Манай улсын хувьд жирэмсэн эмэгтэйчүүдэд ял оногдуулах, ял эдлүүлэх талаархи заалтууд Эрүүгийн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудад тусгагдсан байдлаар, Жирэмсэн эмэгтэй нь нэг биш хоёр хүн, өөрөөр хэлбэл хүүхэдтэй хүн гэсэн ойлголтыг агуулж байдаг. Хүүхэд нь тухайн эмэгтэйн гэр бүлийн гишүүн болж байдаг.

Эхийн хэвлийд байгаа хүүхэд болон эхээс төрөөд иргэний эрхийн чадвартай болж байгаа

хүүхэд хоёрын хоорондын ялгаа нь зөвхөн цаг хугацааны асуудал л байдаг. Иймд эхийн хэвлийд байгаа хүүхдийг эхтэй нь хорьж болдог, эхээс нэгэнт төрчихсөн байгаа хүүхэд ялыг халдаан хэрэглэж болохгүй гэдэг хууль эрхийн акт нь үнэхээр буруу ойлголт юм. Ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно гэсэн Үндсэн хуулийн заалт нь тухайн ялыг ялтны аав, ээж, ах, дүү, хүүхэд, хамаатан садан цаашлаад хэнд ч халдаан хэрэглэж болохгүй гэсэн ойлголт юм. Гэтэл одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай болон Эрүүгийн хуулиудад жирэмсэн эмэгтэйчүүдэд хорих ял оногдуулах, хорих ял эдэлж байгаад төрсөн эмэгтэйг хүүхэдтэй нь цуг байлгаж болох талаархи заалт нь ялыг гэр бүлийн гишүүнд нь халдаан хэрэглэж байгаа явдал юм.

Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлд зааснаар эмэгтэй ялтны ялыг зөвхөн эмэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлэх, жирэмсэн эмэгтэй ялтныг тусад нь байрлуулна гэж заажээ. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 5 дэх хэсэгт "Ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтны 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно" гэж заажээ.

Жирэмсэн эмэгтэйчүүдэд хорих ял оногдуулах, түүнчлэн ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арван зургадугаар зүйлийн 14-т заасан "гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно" гэсэн заалтыг шууд зөрчиж байна. Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчин жирэмсэн эмэгтэйчүүдийг хэвлийдээ тээж байгаа хүүхэдтэй нь хорихоор хуульчилсан нь эх хүнийг үр хүүхэдтэй нь хорьж байгаа явдал юм.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчиж байгаа Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2, 111.5 дахь заалт мөн Монгол Улсын Эрүүгийн хуулийн жирэмсэн эмэгтэйчүүдэд ял оногдуулахтай холбогдолтой заалтуудыг хүчингүй болгож өгнө үү" гэжээ.

**Хоёр. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Шаравдорж Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:**

"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2, 111.5 дахь заалтууд нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11-д "Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална" гэж заасан билээ.

Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцид хүүхдийг гэр бүл, эцэг, эхээс нь хууль бусаар салгаж үл болно. Хүүхдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор зөвхөн хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүхийн шийдвэрээр эцэг, эхээс нь тусгаарлаж болно гэсэн бол, Гэр бүлийн тухай Монгол Улсын хуульд зааснаар хүүхдээ асран хүмүүжүүлэх үүргээс зайлсхийсэн, эцэг, эх байх эрхээ урвуулан ашигласан, хүүхэдтэйгээ удаа дараа хэрцгий харьцсан, хүүхдийн эрүүл мэнд, хүмүүжилд муугаар нөлөөлсөн хүмүүсийн эцэг, эх байх эрхийг нь шүүхийн шийдвэрээр хасч болно гэж тус тус заажээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно гэж заасныг тус хуулийн үзэл баримтлалын дагуу хоёр талтай ойлгож болно.

**Нэгдүгээрт**, үйлдсэн хэрэг нь хүндэвэр, эсхүл хүнд, түүнийг анх удаа үйлдсэн бол жирэмсэн буюу бага насны хүүхэдтэй эмэгтэйн хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг Эрүүгийн хуулийн 63 дугаар зүйлийн дагуу 2 жил хүртэл хугацаагаар хойшлуулж байгаа билээ.

**Хоёрдугаарт**, Эрүүгийн хуулийн 63 дугаар зүйлд онц хүнд гэмт хэрэг үйлдсэн жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх хамаарахгүй байгаа тул онц хүнд гэмт хэрэг үйлдсэн бөгөөд ял эдэлж байх хугацаандаа амаржсан эмэгтэй ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт түр хугацаанд байлгаж болохоор хуульд тусгасан юм. Дээр дурдсан хугацаанаас хойш тухайн хүүхдийг эцгийн, эсхүл бусад төрөл садангийн нь асрамжид шилжүүлнэ. Энэ нь өөрөө манай төрийн энэрэнгүй бодлоготой нийцэж байгаа юм.

Мөн төрөөс хүн амын талаар баримтлах бодлого нь хүүхдийг эцэг, эхийн ивээл хайр асрамжинд нь эсэн мэнд бойжиход нь чиглэгдэнэ, мөн хүүхдийг хөхөөр хооллох, бие, сэтгэлийн

хөгжилд тохирсон хоол хүнсээр хангах, бие бялдгар, оюун санааны өсөлт, хөгжилд нь хяналт тавихыг бүх талаар дэмжихэд чиглэгдэнэ гэж заасныг анхаарахгүй байж болохгүй. Энэ зорилт Улсын Их Хурлаас батлагдсан бусад хууль тогтоомжид ч тусгалаа олсон билээ. Тухайлбал, Эхийн сүү орлуулагч бүтээгдэхүүний тухай хуулийн дагуу хүүхдийг 6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллоно гэж заасан юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн "жирэмсэн болон насанд хүрээгүй эмэгтэй ялтныг тусад нь байрлуулна" гэсэн заалт нь эрх чөлөө нь хасагдсан насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах НҮБ-ын дүрэм, насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан стандартын наад захын журам /Бээжингийн журам/-ын зарчим, үзэл санаанд нийцэж байгаа заалт болно.

Үүнээс гадна НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1988 оны 12 дугаар сарын 9-ны өдөр баталсан Аливаа хэлбэрээр баривчлагдсан болон хоригдсон этгээдүүдийг хамгаалах зарчмууд гэсэн 47/173 тоот шийдвэрийн дагуу үндэсний хууль тогтоомжийн хүрээнд бөгөөд эмэгтэйчүүд, ялангуяа жирэмсэн эмэгтэйчүүд, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, түүнчлэн хүүхэд, насанд хүрээгүйчүүд, ахмад настан, тахир дутуу хүмүүсийн эрх, онцгой байдлыг хамгаалах зорилгоор авсан бүх арга хэмжээг ялгаварлан гадуурхсан буюу эрхийг нь зөрчсөн арга хэмжээ хэмээн үзэхгүй гэж байдаг.

Иргэн Н.Идэр нь "жирэмсэн эмэгтэй нь нэг биш хоёр хүн, өөрөөл хэлбэл хүүхэдтэй хүн гэсэн ойлголтыг агуулж байдаг, хүүхэд нь тухайн эмэгтэйн гэр бүлийн гишүүн болж байдаг" гэжээ.

Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенци болон түүний үзэл санааны дагуу батлагдсан Хүүхдийн эрхийн тухай Монгол Улсын хуулийн дагуу төрснөөс хойш 18 нас хүртэлх хүн бүрийг хүүхэд гэдэг ойлголтод хамааруулахыг хуульчилсан юм. Харин жирэмсэн эмэгтэйн хэвлийд байгаа нь ураг гэж тооцогдоно.

Иймд дээд дурдсан олон улсын эрх зүйн баримт бичиг болон үндэсний хууль тогтоомжийн дагуу жирэмсэн эмэгтэй нь хүүхдийнхээ хамт хоригдож байна гэж үзэх үндэслэл үгүй юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 "Жирэмсэн болон насанд хүрээгүй эмэгтэй ялтныг тусад нь байрлуулна", 111.5 "Ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн "Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл садангийн нь халдаан хэрэглэхийг хориглоно" гэснийг зөрчсөн гэх үндэслэл байхгүй болно" гэжээ.

**Гурва. Маргааныг Цэцгийн хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэх явцад Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4, 7, 8-д заасныг үндэслэн Шүүхийн шийдвэр**



**биелүүлэх ерөнхий газраас зарим мэдээлэл, тэйлбар, тодорхойлолт гаргуулахаар шаардсаны дагуу тус газрын дарга Д.Батжаргал 2006 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 1/3197 тоот албан бичгээ:**

"... 2002 онд шинэчлэн батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.5 дахь хэсэгт "Ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно" гэсэн заалт шинээр орж мөрдөгдөж ирлээ. Энэхүү заалтыг хэрэгжүүлж жирэмсэн болон хүүхэдтэй эхчүүдийн байрыг шинээр бий болгон засварлаж, тохижуулан хүүхдийн амрах, тоглох зэрэг шаардлагатай нөхцлийг нь бүрдүүллээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 332 дугаар зүйлийн 332.1.2-т "... шийтгүүлсэн этгээд жирэмсэн бол төрөхөөс өмнө 45 хоног, төрснөөс хойш 1 жилээс илүүгүйгээр шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж болно" гэж заасан боловч мөн зүйлийн 332.2 дахь хэсэгт "Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн буюу санаатай гэмт хэрэгт удаа дараа шийтгэгдсэн, түүнчилэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон этгээдийн талаар гарсан тогтоол биелүүлэх явдлыг хойшлуулж болохгүй" гэсэн заалтыг үндэслэн онц хүнд гэмт хэрэг үйлдсэн эмэгтэй ялтныг хууль тогтоомжийн дагуу 0-1 насны хүүхдийн хамт байлгаж байна.

Өнгөрсөн хугацаанд тус хорих ангид ял эдэлж байсан эмэгтэйчүүдээс 35 ялтан амаржсанаас 24 нь төрөхөөс өмнө 45 хоног, амаржсаны дараа 1 жилийн хугацаагаар ял хойшлуулж, 4 нь 0-1 насны хүүхдийн хамт ял эдэлж байгаад ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдаж, 2 хүүхдийг ялтны ар гэрт нь, 2 хүүхдийг 1 нас хүрэхэд нь Нялхсын клиник сувилалд тус тус хүлээлгэн өгч шийдвэрлэсэн ба өнөөдрийн байдлаар 0-1 насны хүүхэдтэй 3 ялтан ял эдэлж, тэдгээр хүүхдүүдийн эрүүл мэндэд анхааран холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байгааг танилцуулья" гэжээ.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорих 407 дугаар ангид 0-1 насны хүүхэдтэйгээ ял эдэлж байсан болон одоо ял эдэлж байгаа эмэгтэй ялтнуудын талаар дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлсэн бөгөөд түүнээс үзвэл одоо 0-1 насны хүүхэдтэйгээ, хорих газарт ял эдэлж байгаа 3 ялтан бүгд өрх толгойлсон эмэгтэйчүүд, 2 нь хулгайн гэмт хэрэгт 3 ба 5 удаа Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.4-т зааснаар 10 жилээс дээш /10 жил 6 сар 1 хоног, 10 жил 5 хоног/ хорих ялтай, 1 нь мөн 3 удаагийн ял шийтгэлтэй, танхайн хэрэгт Эрүүгийн хуулийн 181 дүгээр зүйлийн 181.3-т зааснаар 5 жил 10 хоногийн хорих ял шийтгүүлсэн байна. Эдгээр ялтнууд нь бvгд ял эдэлж эхлэхээс өмнө жирэмсэн болоод ял эдэлж байхдаа хүүхдээ туруулсан ажээ.

**Дөрөв. Үндсэн хуулийн цэцэгд мэргээн хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д заасныг**

**үндэслэн Хүний эрхийн үндэсний комиссын даргаас авсан тэйлбар-тодорхойлолтод:**

"Дархан-Уул аймгийн иргэн Н.Идэрийн Үндсэн хуулийн цэцэгд ирүүлсэн өргөдлийн зарим үндэслэлийг Хүний эрхийн үндэсний комисс дэмжиж байна. Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.5 дахь хэсгийн "ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно" гэсэн нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна гэсэнтэй санал нэг байна. Харин Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2 дахь хэсгийг Үндсэн хууль зөрчсөн гэдэгтэй санал нийлэхгүй байна" гэжээ.

Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссоос ирүүлсэн, тус комиссоос Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа эмэгтэйчүүдийн 407 дугаар ангид 2006 оны 6 дугаар сарын 13-ны өдөр хийсэн шалгалтын тайланд "нярай хүүхэдтэй эхчүүдийн байрны өрөө гэрэлгүй, харанхуй", "нярай хүүхэдтэй эхчүүдийн тасгийн угаалгын өрөө нь гал тогоо хөшгөөр тусгаарлаж хийсэн байсан нь эрүүл ахуйн шаардлагад огт нийцэхгүй байсныг онцлон тэмдэглэж байна" гэжээ.

## ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Иргэний хуульд зааснаар болон иргэний эрх зүйн шинжлэх ухааны ойлголт ёсоор иргэний эрх зүйн чадвар нь хүний төрсөн үеэс эхэлж, нас барснаар дуусгавар болдог учир эхийн хэвлийд байгаа ураг нь эрх зүйн харилцааны субъект байх үндэслэлгүй байна. Мөн гэр бүлийн гишүүд төрөл, садны тухай ойлголтыг "Гэр бүлийн тухай" болон "Эрүүгийн байцаан шийтгэх хууль"-д тодорхой хуульчилсан бөгөөд тэдгээрт эхийн хэвлийд байгаа урагийг гэр бүлийн гишүүнд тооцохоор заагаагүй байна. Иймд хорих ял эдэлж байгаа жирэмсэн ялтны хэвлийд буй урагийг ял эдэлж буй мэтээр үзэх, өөрөөр хэлбэл ял эдэлж байгаа жирэмсэн ялтны ялыг түүний гэр бүлийн гишүүнд халдсан хэрэглэхээр хуульчилсан гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.5 "Ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно" гэсэн заалт нь Эрүүгийн хуулийн 63 дугаар зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 332 дугаар зүйлийн 332.2 заалттай холбож хэрэглэгддэг зохицуулалт байна.

Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулиудын дээрх заалтуудаас үзэхэд зөвхөн санаатай гэмт хэрэгт удаа дараа шийтгүүлсэн, онц хүнд гэмт хэрэгт ял шийтгүүлсэн, түүнчилэн онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон эмэгтэй ялтан хорих ял эдэлж байх хугацаандаа амаржвал 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болохоор байна.

Хуулийн энэ зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11-ийн "... Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална" гэсэн заалтад нийцсэн, хүний эрхийн



талаарх олон улсын баримт бичгийн заалтаар зөвшөөрөгдсөн хүрээнд байна.

Харин хорих ял эдэлж байгаа жирэмсэн эмэгтэйнүүд байрлах, тэднийг төрүүлэх, хорих ял эдэлж байгаа эхтэйгээ хамт байгаа 0-1 насны хүүхдийн байрлах байр, тэдгээрийн нөхцөлийг энэ талаарх олон улсын баримт бичигт заасан стандарт хэмжээнд хүргэн сайжруулах асуудлыг төрийн зүгээс анхааран хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2-ын "Жирэмсэн болон насанд хүрээгүй эмэгтэй ялсныг тусад нь байрлуулна"; 111.5-ын "Ял эдэлж байх

хугацаандаа амаржсан ялсныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно" гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн "...гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно" гэснийг зөрчөөгүй байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2-т заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ХУРАЛДААН  
ДАРГАЛАГЧ

Ж.БЯМБАДОРЖ

ГИШҮҮД

Н.ЖАНЦАН  
Ч.ДАШНЯМ  
Д.НАРАНЧИМЭГ  
Ц.САРАНТУЯА

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2006 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

**Засгийн газрын "Журам батлах тухай" 2005 оны 208 дугаар тогтоолын зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим

13.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүн Н.Жанцан, П.Очирбат, Ж.Болдбаатар /илтгэгч/, Ц.Сарантуяа нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны оршин суугч, иргэн С.Эрдэнэчимэг, Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Эрүүл мэндийн дэд сайд А.Отгонболд, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Ч.Наранбаатар нар оролцов.

**Нэг. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны оршин суугч, иргэн С.Эрдэнэчимэг Үндсэн хуулийн цэцэд хандаж 2006 оны 11 дүгээр сарын 3-ны өдөр гаргасан мэдээллэдээ:**

"Засгийн газраас 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр баталсан "Журам батлах тухай" 208 дугаар тогтоол нь Биеийн тамир, спортын тухай

хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-ийн "Олимпын наадам, дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчдыг шагнаж урамшуулах" гэсэн заалтыг зөрчин зөвхөн олимпын наадамд ордог спортын төрлийн тамирчдад шагнал олгохоор хуулийг засварласан байдалтай гарсан нь олимпод ордоггүй спортын төрлийн тамирчдын хувьд тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргавал хөдөлмөрийнхөө үр шимийг үзэх, нийгмийн баталгаагаар хангагдах эрх нь хязгаарлагдаж, улмаар Биеийн тамир, спортын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1 болон Үндсэн хуулийн дараах заалтуудыг зөрчсөн шийдвэр болж байна.

1. Дээрхи тогтоолоор Биеийн тамир, спортын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1-д заасан "...тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд өндөр амжилт гаргасан тамирчид Засгийн газрын мөнгөн шагнал авах" эрх, баталгаа нь олимпод ордоггүй спортын төрлийн тамирчдын хувьд хэрэгжих боломжгүй болж байгаа нь Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-ийн "Засгийн газар ... хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах" тухай заалтыг зөрчиж байна.

2. Биеийн тамир, спортын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1 дэх заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор гарсан Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоол нь хуулийнхаа заалттай ийнхүү зөрчилдөж байгаа нь Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1-ийн "Засгийн газрын тогтоол хууль тогтоомжид нийцсэн байх" тухай заалтыг зөрчиж байна.

3. Уг тогтоол Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 22 дугаар зүйлийн 22.2.1 дэх заалтуудыг засвартай өөрчилсөн байдалтай гарсан нь "Хуульд өөрчлөлт оруулах тухай" Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг Засгийн газар зөрчсөн шинж чанартай байна.

4. Мөн олимпын наадамд ордог, ордоггүй гэдэг хандлага байдлаар спортын салбарынхныг эрхэлсэн ажил, сонгосон спортын төрлөөр нь ялгаварлан үзэх байдал бий болгосон нь олимпод ордоггүй спортын төрлийнхний хувьд сонирхлынхоо дагуу спортын төрлөө сонгон хөдөлмөрлөх, үр шимийг нь үзэх, хөдөлмөрөө үнэлүүлэх тэдний хууль ёсны эрхийг хязгаарлаж "эрхэлсэн ажил, мэргэжлээрээ ялгаварлагдан гадуурхагдахгүй байх" тухай Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2, "Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрлөх аятай нөхцлөөр хангагдах, хөдөлмөрөө үнэлүүлэх" тухай Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтуудыг тус тус зөрчиж байна.

Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтын дагуу энэхүү тогтоолыг хуульд нийцүүлэн өөрчлөх, олимпын бус төрлийнхний зорчигдсон эрхийг сэргээх, учруулсан хохирлыг арилгуулах талаар Засгийн газарт бүтэн жил санал, хүсэлт, шаардлага тавьж ирсэн ч асуудал шийдвэрлэгдэхгүй байгаа учраас асуудлыг шийдвэрлүүлэхээр Үндсэн хуулийн цэцэд хандаж байна. Иймд Үндсэн хуулийн дээрх заалтуудыг зөрчиж байгаа Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн "Журам батлах тухай" 208 дугаар тогтоолыг хянан үзэж хүчингүй болгож өгнө үү" гэжээ.

**Хойр, Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Эрүүл мэндийн дэд сайд А.Отгонболд, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Ч.Наранбаатар нар Үндсэн хуулийн цэцэд хандаж гэрээсэн тайлбартаа:**

"Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоол нь Улсын Их Хурлаас баталсан Биеийн тамир,

спортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор гарсан тогтоол юм. Афины олимпын бэлтгэл ажлыг эрчимжүүлэх зорилгоор "Олимпын наадамд бэлтгэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2001 оны 187 дугаар тогтоол гарч, уг тогтоолоор амжилт гаргасан тамирчдад мөнгөн шагнал олгох тухай журам батлагдсан боловч Афины олимпын тоглолт дууссан, Биеийн тамир, спортын тухай хууль батлагдсантай холбогдуулан дээрх 187 дугаар тогтоолыг хүчингүй болгох шалтгаан болсон.

Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоолын агуулгыг хэт хавтгайруулан Үндсэн хуулийн олон заалтыг зөрчсөн мэтээр үзэх нь хууль зүйн үндэслэлгүй. Энэхүү тогтоолоор баталсан "Мөнгөн шагнал олгох журам" нь олимпод ордоггүй спортын төрлийн тамирчдад хамгааралгүй юм. Яагаад гэвэл Засгийн газар Биеийн тамир, спортын тухай хуулийг хэрэгжүүлэх үүргийнхээ дагуу "Мөнгөн шагнал олгох тухай" журам баталсан тогтоол гаргахдаа бүх спортын төрөлд олговол ямар нөхцөл үүсч болохыг судлан үзсэн. Өөрөөр хэлбэл Олимпын Харти ёсоор Олимпын хөтөлбөрт эрэгтэйчүүдийн оролцох спорт нь 4 тивийн 75-аас доошгүй оронд, эмэгтэйчүүд оролцох спорт нь 4 тивийн 50-аас доошгүй оронд, өвлийн наадамд 3 тивийн 25-аас доошгүй оронд өргөн дэлгэр хөгжсөн спорт орох боломжтой байдгийг харгалзсаны дүнд дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн өргөн дэлгэр хөгжиж Олимпын хөтөлбөрт орсон төрлүүдийг эхний ээлжинд хамруулахаар шийдвэрлэсэн.

Биеийн тамир, спортын салбарын эрхэм зорилгын нэг нь тамирчдын амжилтыг олимпын түвшинд хүргэх явдал юм. Иймд олимпид орсон спортын төрлийг түлхүү хөгжүүлэх, түүгээр хичээллэж амжилт гаргасан тамирчдыг шагнаж урамшуулахыг илүү анхаарсан. Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоол болон түүгээр баталсан "Мөнгөн шагнал олгох журам" нь Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 1, Засгийн газрын тухай хуулийн 30.6, 30.8 дугаар заалтууд болон Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор тэдгээрт нийцүүлэн гаргасан учир хэлбэр, агуулгын хувьд хууль зөрчөөгүй. Түүнчлэн тогтоолыг гаргахад мэргэжлийн хуульчид, агентлаг, яам, Засгийн газрын түвшинд хянан үзсэн.

Улсын Их Хурлаас олгосон бүрэн эрхийнхээ дагуу Засгийн газрын тухай хуулийн 30.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.4 дүгээр заалтуудад нийцүүлэн Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоолоор "Мөнгөн шагнал олгох журам"

баталсан нь Засгийн газар үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж хууль зүйн үндэслэлтэй шийдвэр гаргасан учир бүхэлдээ Үндсэн хуулийн ямар ч заалтыг зөрчөөгүй, харин ч Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцэж байгаа болно.

Иргэн С.Эрдэнэчимэгийн бичсэн зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн зүйл, заалтыг зориудаар эсвэл андуу ташаа ойлгосон мэтээр утга агуулга гаргасан байгаа учир Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэн хэлэлцэх хууль зүйн үндэслэлгүй байгаа юм гэжээ.

**Гурав.Засгийн газрын итгэмжлэгдсэн тоолоогч, Эрүүл мэндийн сайд А.Отгонболд, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга Ч.Наранбаатар нар Үндсэн хуулийн цэцэд хандаж 2006 оны 12 дугаар сарын 18-ны өдөр гаргасан нэмэлт тайлбартаа:**

"Засгийн газар Улсын Их Хурлаас хуулиар тусгайлан эрх олгосон нөхцөлд хуульд нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрхийн акт гаргаж болно" гэж Засгийн газрын тухай хуулийн 30.2-т заасны дагуу Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.4 дүгээр заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2005 оны 208 дугаар тогтоолоор "Мөнгөн шагнал олгох тухай" журам баталж түүгээрээ "олимпын наадамд орох спортын төрөл" гэж тодотгосон нь нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээг тогтоосон гэж үзэх үндэстэй байна.

Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоолоор Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.4 дүгээр заалтад заасан Олимпын наадам, дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчдад мөнгөн шагнал олгож байгаа.

Тухайлбал, Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоол гарснаас хойш зөвхөн 2006 онд Оюутны дэлхийн аварга шалгаруулах чөлөөт бөхийн тэмцээн, Дэлхийн цомын аварга шалгаруулах буудлагын тэмцээн, Дэлхийн аварга шалгаруулах буудлагын тэмцээн, Оюутны дэлхийн аварга шалгаруулах боксын тэмцээн, Насанд хүрэгчдийн Ази тивийн аварга шалгаруулах чөлөөт бөхийн тэмцээн, Ази тивийн хүндийн өргөлтийн залуучуудын аварга шалгаруулах тэмцээн, Ази тивийн залуучуудын аварга шалгаруулах жудо бөхийн тэмцээн, Өсвөр үеийн Азийн аварга шалгаруулах чөлөөт бөхийн тэмцээн, Залуучуудын Азийн аварга шалгаруулах боксын тэмцээн, Өсвөр үеийн Азийн аварга шалгаруулах боксын тэмцээн

амжилт гаргасан тамирчдад Засгийн газрын мөнгөн шагнал олгосон.

Манай улсад Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэлтэй спортын 70 гаруй холбоо, 400 гаруй спортын клубууд үйл ажиллагаагаа явуулж байна. Хэрэв Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоолоор мөнгөн шагнал авах тамирчдын спортын төрлийг тодотгож заагаагүй бол дээрх холбоод, клубууд нь өөрийн спортын төрлөөр цөөхөн хэдэн орны ижил төрлийн холбоодтой хамтран тив, дэлхийн тэмцээн зохион байгуулж медальт байранд шалгарсан тамирчин бүрт Засгийн газрын мөнгөн шагнал олгохоор бол улсын төсвөөс хир хэмжээний мөнгө гарах нь тодорхой байгаа юм. Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоолоос өмнө тамирчдад олгож байсан мөнгөн шагналын судалгааг харуулбал,

2001 онд олимпын 3 спортын төрлийн 5 тамирчинд 23.7 сая төгрөгийн, олимпын бус 3 спортын төрлийн 44 тамирчинд 93.2 сая төгрөгийн, 2002 онд олимпын 6 спортын төрлийн 23 тамирчинд 96.2 сая төгрөгийн, олимпын бус 12 спортын төрлийн 104 тамирчинд 175.2 сая, 2003 онд олимпын 6 спортын төрлийн 29 тамирчинд 88.5 сая төгрөгийн, олимпын бус 6 спортын төрлийн 89 тамирчинд 136.2 сая төгрөгийн, 2004 онд олимпын 4 спортын төрлийн 111 тамирчинд 184.2 сая төгрөгийн шагналыг тус тус олгосон байна.

Зөвхөн 2001-2004 онд олгосон мөнгөн шагналын судалгаанаас үзэхэд нийт 874.5 сая төгрөг олгогдсоноос 603.7 сая төгрөг буюу 69.0 хувь нь олимпын бус төрөлд амжилт гаргасан тамирчдад олгосон байна. Мөн олимпын болон олимпын бус төрлийн дэлхий болон тивийн аварга шалгаруулах тэмцээнд оролцсон улс орныг авч үзэхэд олимпын төрлийн дэлхийн аваргын тэмцээнд 30-100 орон хамрагдаж байгаа бол олимпын бус төрлийн тэмцээнд 15-20 орон, олимпын төрлийн тивийн аварга шалгаруулах тэмцээнд 15-42 орон хамрагддаг бол олимпын бус төрлийн тэмцээнд 5-8 орон хамрагддаг нь судалгаагаар батлагдаж байна.

2001-2005 оны 9 дүгээр сар хүртэл мөрдөж байсан журмаар олгож байсан мөнгөн шагнал нь хэт хавтгайрсан, тамирчдын олимпын төрөлд амжилт гаргах сонирхлыг бууруулсан, Биеийн тамир, спортын салбарын тамирчдын амжилтыг олимпын түвшинд хүргэх зорилго алдагдах болсон зэрэг шалтгаанаас шалгуур үзүүлэлт зайлшгүй хэрэгтэй байсан нь эхний ээлжид олимпын төрөлд багтдаг спортын төрөлд мөнгөн шагнал олгох шаардлагатай болсон явдал юм.



Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтын дагуу Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.4 дэх заалтыг хэрэгжүүлж, биелэлтийг улс орон даяар зохион байгуулж хангах үүргээ биелүүлж байна. Иймд Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтыг зөрчөөгүй болно.

2. Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоол нь Биеийн тамир, спортын тухай хуулийн 22.2.1 дэх заалтыг хэрэгжүүлж байна гэж үзэж байна.

Тухайлбал, Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоолоор баталсан "Мөнгөн шагнал олгох тухай журам"-ын дагуу 2005 оноос хойш олимпын төрөлд багтдаг спортын төрлөөр тив, дэлхийн тэмцээнд амжилт гаргасан 66 тамирчинд 290.8 сая төгрөгийн мөнгөн шагнал олгосон нь Биеийн тамир, спортын тухай хуулийн 22.2.1 дэх заалтын дагуу тамирчид Засгийн газраас мөнгөн шагнал авах гэсэн баталгааг хангасан байна. Иймд Үндсэн хуулийн Дечин тавдугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчөөгүй болно" гэжээ.

## ҮНДЭСЛЭЛ:

Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн "Журам батлах тухай" 208 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1/, Дечин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн болох нь дараахь үндэслэлээр тогтоогдож байна.

1. Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоол нь Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-ийн "Олимпын наадам, дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнд амжилт гаргасан тамирчдыг шагнаж урамшуулах"; мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1-д "тамирчин олимпын наадам, дэлхий, тивийн аварга болон улсын аварга шалгаруулах тэмцээнд өндөр амжилт үзүүлбэл Засгийн газраас мөнгөн шагнал... авах" гэсэн заалтыг "олимпод багтах спортын төрөл"-өөр гэж явцууруулж, мөн олимпын бус төрлөөр дэлхий, тивийн аварга шалгаруулах тэмцээнд медаль авсан тамирчны хуульд заасан шагнал авах эрхийг хассан байна.

2. Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоол Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 22 дугаар зүйлийн 22.2.1 дэх заалтыг зөрчсөнөөрөө Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1/-ийн "Засгийн газар... хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах", Дечин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд тогтоол, захирамж гаргах" гэсэн заалтыг тус тус зөрчсөн шинжтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн "Журам батлах тухай" 208 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1/, Дечин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчсөн байна.

2. Засгийн газрын 2005 оны 208 дугаар тогтоолын үйлчлэлийг 2007 оны 1 дүгээр сарын 5-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ХУРАЛДААН  
ДАРГАЛАГЧ

Ж.БЯМБАДОРЖ

ГИШҮҮД

Н.ЖАНЦАН  
П.ОЧИРБАТ  
Ж.БОЛДБААТАР  
Ц.САРАНТУЯА

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргах  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмгэгтэйчиг зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэлэлцэх хэсэгт хэвлэв

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 255956  
Индекс 14003

☎ 329487  
Хэлэлцлийн хуудас 3.5

